МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.03.31 № УИЗ-03/3758
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Ж.АЛДАРЖАВХЛАН

А.АРИУНЗАЯА

Н.БАТСҮМБЭРЭЛ

2025000242

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.03.31 № УИХ-03/3734
танай -ны № -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол улсын Засгийн газраас хуулийн төсөлд санал, дүгнэлт гаргуулахаар 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн УИХ-03/2042 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь хэсэгт заасны дагуу тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.

Хуулийн төслийг холбогдох хууль, журмын дагуу Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх товыг тогтоож өгнө үү.

Хуулийн төслийг холбогдох баримтын хамт хавсаргав.
Хавсралт 14 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.ЧИНБҮРЭН

2025000233

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.02.13 № УИХ-03/2042
танай -ны № -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Хуулийн төсөлд санал
авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

"Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 115 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.ЧИНБҮРЭН

2025000207

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЧИНБҮРЭН

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлд "Монгол Улсын иргэн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах..." эрхтэй гэж заасан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын ерөнхий ассамблейгаас баталсан Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын 3-д нийгмийн эрүүл мэндийн бүх нийтээр хамралтад хүрэх зорилтыг тодорхойлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрхийг хангахын тулд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг гишүүн орнууддаа зөвлөсөн.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2010 оны 5 дугаар сард хуралдсан 63 дугаар чуулганаар "Resolution WHO 63.22" шийдвэрийг баталсан. Энэхүү шийдвэрийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг баримталж ажиллах 11 заалт бүхий зарчмуудыг тодорхойлсон бөгөөд энэ зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллахыг гишүүн орнууддаа зөвлөмж болгосон.

Мөн УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22–ны өдрийн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 12 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилготой болно.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030-д зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах гэсэн зорилт дэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал "Алсын хараа 2050" болон ЗГ-аас 2017 онд баталсан 24 дүгээр тогтоолд "Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах" зорилтыг тус тус тодорхойлсон.

Түүнчлэн Монгол Улсад Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг зохицуулах биеэ даасан хууль өнөөг хүртэл байгаагүй болно. Эдгээр

бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага гарсан болно.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Анх Донорын тухай хууль 2000 онд батлагдсан бөгөөд тус хууль нь цусны донорын үйл ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулж буй цөөн хэдэн заалт орсон байдаг. Монгол Улсын Их Хурлаас "Донорын тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталж одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэдий ч өнөөгийн цаг үеийн шаардлагыг бүрэн хангахгүй болсон. Цусны донорын үйл ажиллагааны зохицуулалтын хуулинд Эрхтэн, эд, эсийн эмчилгээний зарим зохицуулалтыг хавсаргаж оруулсан. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний онцлог, мэргэжил тус бүрийн нарийн төвөгтэй олон асуудлууд зохицуулагдаагүй орхигдсон буюу "Донорын тухай" хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулах явцад энэ бүх асуудлуудыг нэмэлт өөрчлөлтөд багтаан оруулах боломжгүй байсан. Иймд эдгээр олон асуудлуудыг зохицуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, бие даасан хууль боловсруулан гаргах нь практик, үйл ажиллагааны явцад зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон.

Дэлхийн 93 улс оронд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг ямар нэг хэмжээгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 90 оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай биеэ даасан хууль тогтоомж байдаг байна. Монгол улс нь хөгжиж буй орон бөгөөд эдийн засаг , санхүүгийн хувьд хязгаарлагдмал бололцоотой хэдий ч энэхүү эмчилгээний төрлүүдийг хамтад нь амжилттай хийж гүйцэтгэж байгаа цөөн орны тоонд багтдаг.

Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийснээс хойш 2023 оны 12 дугаар сарыг хүртэл Улсын Нэгдүгээр төв эмнэлэгт 331 иргэнд бөөр (41 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 234 иргэнд элэг (12 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан), Хавдар судлалын үндэсний төвд нийт 118 хүнд элэг шилжүүлэн суулгах (эдгээрээс 10 хүнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан) тус тус амжилттай шилжүүлэн суулгах эмчилгээг хийсэн байна.

Түүнчлэн эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд хурдацтай хөгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох хүсэл мөрөөдлийг нь биелүүлж байна. Одоогоор 24 иргэнд ясны чөмөгний үүдэл эс, 24 иргэнд нүдний эвэрлэг, 1735 иргэнд арьс, 150 гаруй иргэнд шөрмөс, 974 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг хийж 442 амьд хүүхэд төрсөн байна.

Монгол Улсын хүн ам тогтвортой өсөн нэмэгдэж одоо 3.4 сая гаруй болсон бөгөөд хүн амын дунд 45 хүртэлх настай иргэд 2 615 270 буюу хүн амын 70 гаруй хувийг эзэлж байна. Хүн ам тогтвортой өсч, залуучуудын эзлэх хувь өндөр байгаа нь ирээдүйд өвчин эмгэг өсөх хандлагатай байна гэдгийг харуулж байна. Энэ хэрээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээний хэрэгцээ шаардлага улам их болно.

Амьгүй донороос эрхтэн, эд шилжүүлэн суулгах эмчилгээг өргөжүүлэн нэг донороос аль болох олон хүнд шинэ амьдрал өгч амьдралын чанарыг нь дээшлүүлэх зорилгоор нойр булчирхай болон зүрх шилжүүлэн суулгах үндэсний багуудыг байгуулан бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.

Үүний зэрэгцээгээр үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах, эмчлэгдэхгүй байгаа олон төрлийн өвчнүүдийг эмчлэх арга замыг нээх цаашлаад хүйн цус, эс, эдийг хадгалах сан байгуулах эсийг олшруулан урган төлжүүлэх шинэ арга технологи эмчилгээ үйлчилгээний практикт ашиглах, нэвтрүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага амьдрал практикт тулгараад байгаа билээ.

Дэлхийн улс орнуудад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээ эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд энэ төрлийн эмчилгээ нь тухайн эрхтэн, эд, эсийг шинэ эрхтэн, эд, эсээр сольж, нөхөн төлжүүлж өвчнийг бүрэн анагаах, амьдралын чанарыг эрс сайжруулдаг тул улс орон бүр энэ салбарт маш их хөрөнгө, санхүү, хүн хүч зарцуулж байна. Энэ ч утгаараа маш олон төрлийн шинэ судалгаа, туршилтууд хийгдэж эмчилгээний шинэ аргууд нэвтэрч байна.

Гэсэн хэдий ч эмчилгээний арга хөгжихийн хажуугаар сөрөг үр дагавар гарч байгаа бөгөөд түүний эсрэг 2008 онд Турк улсын Станбул хотод дэлхийн 145 орны эрүүл мэндийн сайд нарын уулзалт болж Declaration of Istanbul буюу Станбулын тунхаглал баталсан. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний үед хүний наймаа, хүний эс, эд, эрхтний наймаа, эрхтэн шилжүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг хамтран ажиллах тунхаглалд гарын үсэг зурцгаасан юм. Монгол улс энэхүү тунхаглалд 2018 онд Испани улсад болсон дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгийн 27 дугаар их хурлын үеэр элсэн орсон.

Түүнчлэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2010 оны 5 дугаар сард хуралдсан 63 дугаар чуулганаар "Resolution WHO 63.22" шийдвэрийг баталсан. (Resolution WHA 75 Apl 2022 шинэчлэгдэн батлагдсан) Үүнд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж буй улс орнуудад хандан ДЭМБ-аас эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үед баримтлах ерөнхий зарчим заавар гаргаж өгсөн. Энэ нь нийт 11 ерөнхий зарчимтай бөгөөд аливаа улс орон өөрийн орны хууль дүрэм, журамд эдгээр зарчмуудыг тусган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Манай улсын одоо хэрэгжиж буй "Донорын тухай" хууль болон бидний боловсруулж буй "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хууль нь эдгээр зарчимд үндэслэн боловсруулагдаж байгаа болно.

Энэхүү зарчмуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2010 онд Испани улсын Мадрид хотноо "The Madrid Resolution Self-Sufficiency" зарчмыг баталса. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж буй аливаа орон юуны түрүүнд донорын эрхтэн, эд, эсээр өөрийн орны хэрэгцээг хангах тухай зөвлөмж юм. Энэ нь эрхтэн, эд, эсийг өөр орон руу дамжуулах, худалдан наймаалцах үйл ажиллагааг хязгаарлахтай холбоотой зохицуулалт болно. Гэхдээ улс орнуудын хооронд эрхтэн хуваарилалт (OrganSharing) хийдэг хамтарсан тогтолцоонууд байдаг.

Эдгээр бодлогын баримт бичгүүдын үзэл баримтлал, хэрэгжилтийг хангах үүднээс "Донорын тухай" хуулийг баталсан бөгөөд цаашлаад эрхтэн, эд, эс

шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нь хуулийн хүрээнд явагдах, иргэдэд дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ үйлчилгээг хүргэхтэй холбоотой асуудлыг зохицуулах эрх зүйн баримт бичгийг хуульчлан батлах хэрэгцээ байна. Тус хуульд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээтэй холбоотой нарийн төвөгтэй, мэргэжлийн онцлог бүхий асуудлуудыг дэс дараалалтай шийдвэрлэж байх зарчмыг баримталж хуулийн төслийг боловсруулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалаар мэргэжил бүрээс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан ажилласан билээ. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нь биеэ даасан тус тусдаа хөгжин, өргөжин тэлж байгаа салбарууд бөгөөд энэ хуулинд тус тусдаа тусгай бүлэг болон орохоор төлөвлөгдсөн болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор сайн дурааараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эмчилгээг тэгш, хүртээмжтэй, үнэн шудрага байх зарчмыг баримтлан ажиллах, эмчилгээ үйлчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх, илүү хурдацтай хөгжих боломж нөхцлийг бүрдүүлэх эрх зүйн орчинг тусгаж өгнө. Түүнчлэн Ёс зүйн хороо байгуулах, нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулан ажиллуулах, донорт олгох санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцааг тодорхой болгох, хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төр хариуцах, эрүүл мэндийн байгууллага бүрт амьгүй донороос эрхтний донорын үйл ажиллагааг дэмжин ажилладаг тогтолцоог бий болгох талаар зохицуулсан. Монгол улсын эрүүл мэндийн салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах болон донор эмнэлгүүдийн хоорондын хамтын үйл ажиллагааг дэмжих, чадавхийг сайжруулах, улам боловсронгуй болгох, тус салбарын эмч, ажилчдын цалин хөлс, урамшуулал хийгээд салбарын тогтвортой хөгжил, хэрэгцээт тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлийн хангалт, туршилт, судалгаа, тасралтгүй сургалт, тогтвортой санхүүжүүлт зэрэг харилцаануудыг зохицуулахад оршино.

Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна.

1. Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томьёоны тодорхойлолт болон үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.

2. Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт реципиент болон амьд донорыг сонгох, тэдгээрийн эрх үүрэг, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх болон тавигдах шаардлагын талаар тусгана.

3. Хуулийн гуравдугаар бүлэгт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгах ба эрхтэн, эд, эс авах,

шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгана.

4. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар тусгана. Уг үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоог тодорхойлж, Монгол Улсын засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг тусгана. Мөн эрхтэн эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн байгууллагын нийтлэг чиг үүргийг тусгана.

5. Хуулийн тавдугаар бүлэгт бусад зүйл, санхүүгийн тогтолцоо, хяналтын тогтолцооны талаар тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

1. Одоогоор бүрэн зохицуулагдаагүй байгаа эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний харилцаа бүрэн зохицуулагдах эрх зүйн орчин бүрдэнэ.

2. Хуулийн төсөл батлагдсанаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний хүрээ нэмэгдэж, гадагш явж тусламж үйлчилгээ авч буй иргэдийн тоо буурч, эх орондоо дэлхийн жишигт хүрсэн эмчилгээ үйлчилгээг авах боломж илүү болж, иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх хангагдана.

3. Хуулийн төсөл батлагдсантай холбоотой улсын төсөв, санхүүгийн нэмэлт зардал богино хугацаандаа гарах боловч урт хугацаандаа эх орондоо чанартай, хүртээмжтэй дэлхийн жишигт хүрсэн эмчилгээний тусламж үйлчилгээ нэмэгдэж гадагш гарах олон сая валютыг хэмнэх боломж бүрдэнэ.

4. Хүйн цус, эс, эдийн сан байгуулагдснаар одоо эмчилэх боломжгүй байгаа олон төрлийн өвчнийг эмчлэх боломжийг хангахад том алхам болно.

5. Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ нэмэгдэж, амьд донорыг хамгаалах үйл явц сайжирна. Хүний наймаа болон хүний эрхтний наймаанаас сэргийлэх нөхцөл улам сайжирна.

6. Төр даах тусламж үйлчилгээнд хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зардлыг оруулан тооцсоноор эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтын зөрүүг төр даах бөгөөд жилд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тоо цөөн тул хуулийн төслийг батлан хэрэгжүүлэхэд улсын төсөвт төдийлөн ачаалал үүсгэхгүй.

7. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгоно.

8. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний хэрэгцээ шаардлага улам их болж буй бөгөөд үүнтэй холбоотойгоор эмчилгээ, үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага үүснэ. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллага байгуулах нь зайлшгүй болохыг илтгэж байна.

9. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тусламж үйлчилгээг нэг дор үзүүлж байгаа улс орон цөөн байгаа бөгөөд манай орон шиг хөгжиж буй орнууд эдгээр эмчилгээг нэгэн зэрэг хийх боломжгүй байгаа нь Монгол улын эрүүл мэндийн салбарын нэр хүнд, эзлэх байр суурийг тодорхой өндөр түвшинд байгааг илтгэж байдаг.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хуультай нийцсэн байх бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Донорын тухай хууль хүчингүй болох бөгөөд тус хуулийг дагаж гарсан журмууд өөрчлөгдөн дахин боловсруулагдана.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийн тухай

Монгол Улсад анх 2000 онд Донорын тухай хууль батлагдаж байсан бөгөөд энэ хуулийн үндсэн санаа, агуулга нь цусны донорын үйл ажиллагааг зохицуулах зориулалттай байсан ба 2012, 2014, 2015, 2021 онуудад нэмэлт өөрчлөлт хийсэн байна. Энэ хугацаанд манай улсын анагаах ухааны салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ улам хөгжин, өргөжин тэлж, эмчилгээний арга хэлбэр, тоо, чанар зэрэг нь хөгжлийн шинэ үе шатанд гарсантай уялдан дээр дурьдсан удаа дараагийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгаар эрхтний донор, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх заалтууд нэмт тусгаж ирсэн.

Монгол Улсад эрхтэн, эд , эс шилжүүлэн суулгах эмчилгээ хөгжиж ирсэн талаар:

Монгол улсад анх 2006 онд бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг УКТЭ-т амжилттай хийснээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ эхэлсэн. Үүнээс хойш УКТЭ-т 2011 онд элэг шилжүүлэн суулгах баг, 2014 онд ясны чөмөг, үүдэл эс шилжүүлэн суулгах баг, ХСҮТ-д 2018 онд элэг шилжүүлэн суулгах баг тус тус баг байгуулагдаж шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна. Түүнчлэн эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд хурдацтай хөгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох хүсэл мөрөөдлийг нь биелэл болгож байна

Ирээдүйн чиг хандлага , түүний төсөөллийн талаар:

Үүний зэрэгцээгээр үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах цаашлаад хүйн цус, эс, эдийг хадгалах банк байгуулах эсийг олшруулан урган төлжүүлэх шинэ арга технологи эмчилгээ үйлчилгээний практикт ашиглах, нэвтрүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага амьдрал практикт тулгараад байгаа билээ. Учир нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад энэ төрлийн эмчилгээ үйлчилгээний салбар эрчимтэй хөгжин өргөжин тэлж энэхүү эмчилгээнээс гарсан үр дүнд суурилсан судалгаа шинжилгээ, эмчилгээний чанар хүртээмжийг улам сайжруулах хөгжүүлэх ажлууд өргөн хийгдэж байна. Манай улс эрүүл мэндийн салбарын энэхүү дэвшилтэд шинэ арга технологуудийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Баримтлах бодлогын чиг баримжаа :

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах холбооны удаа дараагийн тогтоол, зөвлөмж, санамж бичиг, Улсын их хурлаас батлсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, "Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн

чиглэл батлах тухай" тогтоолыг тус тус Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг боловсруулах чиг баримжаа болов.

Дэлхийн улс орон олон улсын жишиг:

Дэлхийн 93 улс оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг ямар нэг хэмжээгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 90 оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай биеэ даасан хууль тогтоомж байдаг байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:

1. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж үүний хэрээр энэхүү эмчилгээний аргууд улам нэмэгдэж хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
2. Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж нэмэгдэнэ. Гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасаж, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
3. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарна.
4. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинө. Энэ нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулагдах суурь нөхцөл болно.
5. Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах бодлого, зохицуулалт улам төгөлдөржин нэгдсэн сүлжээ, тогтолцоо бий болон хөгжиж эмчилгээний төрөл, чанар, хүртээмж, үр дүн илүү сайжирна.

Хууль санаачлагчид

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

"Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийн тухай

Монгол Улсад анх 2000 онд Донорын тухай хууль батлагдаж байсан бөгөөд энэ хуулийн үндсэн санаа, агуулга нь Цусны донорын үйл ажиллагааг зохицуулах зориулалттай байсан ба энэ хуулинд эрхтний донор, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар заалт хавсаргаж оруулсан. Энэ хугацаанд манай улсын анагаах ухааны салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ улам хөгжин, өргөжин тэлж, эмчилгээний арга хэлбэр, тоо, чанар зэрэг нь хөгжлийн шинэ үе шатанд гарсаар байгаа билээ. Үүнтэй уялдан Монгол Улсын Их Хурлаас Донорын тухай хуулийг 2012, 2014, 2018 онуудад шинэчилсэн найруулан өөрчлөлт хийсэн бөгөөд хамгийн сүүлд 2022 онд Донорын тухай хуулийн дахин шинэчлэн найруулан баталж одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Шинэчлэн найруулга хийхдээ нийт 5 зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус хуулиар хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дурааараа цус, эс, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаархи төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Донорын тухай (шинэчилсэн найруулга) хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд үүний учир шалтгаан нь анагаах ухааны практикт эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын шинэ технологи нэвтэрч эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хүн амын дунд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх шаардлагатай эрхтэн тогтолцооны өвчин эмгэг нь төгсгөлийн үе шатандаа орсон иргэдийн тоо нэмэгдэж, сүүлийн 10 гаруй жил нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, элэг, бөөрний эмгэг, хорт хавдар, осол гэмтэл орсон хэвээр байна.

Нэмэлт, өөрчлөлтийн төсөлд донорын насны доод хязгаарыг багасгах ,амьгүй буюу тархины үхэлтэй донорын гэр бүлд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох, амьгүй донорын гэр бүлд хүндэтгэл үзүүлэх, эс, эд эрхтэн шилжүүлэн суулгахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэх ёс зүйн хороо байгуулах зэрэг асуудлууд тусгагдсан болно.

Эдгээр өөрчлөлтүүдийг цаг тухай бүрт хэрэгцээ шаардлагын үүднээс хийж байсан хэдий ч уг хуулийг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай бүхэл бүтэн биеэ даасан хууль эрх зүйн акт бий болгох цаашлаад уг хуулийн агуулга, хамрах хүрээ, үзэл баримтлал, процессын зохицуулалтуудыг шийдэх хэмжээнд бус байгаа энэхүү хуулийг боловсруулах үндсэн шаардлага болж байна.

Монгол Улсад эрхтэн, эд , эс шилжүүлэн суулгах эмчилгээ хөгжиж ирсэн талаар:

Монгол Улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай хийснээс хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар 331 иргэнд бөөр (284 иргэнд амьд донороос, 47 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 362 иргэнд элэг (337 иргэнд амьд донороос, 25 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан).



	1996-2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Тархины үхэлтэй донор	0	0	0	2	2	2	0	2	0	0	0	6	0	2	19	10	15	6	6
Амьд донор	1	8	4	12	9	9	11	9	16	23	21	23	27	53	49	52	51	109	135

Хүснэгт 1. Монгол улсын хэмжээнд амьд болон амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн тоон үзүүлэлт

Түүнчлэн эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд хурдацтай хөгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох хүсэл мөрөөдлийг нь биелэл болгож байна Одоогоор 29 иргэнд ясны чөмөгний үүдэл эс, 24 иргэнд нүдний эвэрлэг, 735 иргэнд арьс, 150 гаруй иргэнд шөрмөс, 373 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг тус тус амжилттай хийсэн байна.

	1996-2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Элэг	0	0	0	0	0	0	3	4	4	5	6	9	9	30	39	32	44	75	102
Бөөр	1	8	4	14	11	11	8	7	12	18	15	20	18	25	29	29	22	40	39

Хүснэгт 2. Монгол улсын хэмжээнд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн тоон үзүүлэлт

Манай улсын хэмжээнд бөөр болон элэг, нүдний эвэрлэг, зүрх, нойр булчирхай шилжүүлэн суулгах эмчилгээ шаардлага олон зуун иргэн байгаа бөгөөд одоогоор бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний хүлээх жагсаалтад 350, элэг шилжүүлэн суулгах хүлээх жагсаалтад 250 гаруй иргэн бүртгэлтэй байгаа болно. Энэ тоо нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 3. Монгол улсын хэмжээнд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн тоон үзүүлэлт

Ирээдүйн чиг хандлага , түүний төсөөллийн талаар:

Үүний зэрэгцээгээр үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах, үр хөврөл шилжүүлэн суулгах цаашлаад хүйн цус, эс, эдийг хадгалах банк байгуулах эсийг олшруулан урган төлжүүлэх шинэ арга технологи эмчилгээ үйлчилгээний практикт ашиглах, нэвтрүүлэн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага амьдрал практикт тулгараад байгаа билээ. Учир нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад энэ төрлийн эмчилгээ үйлчилгээний салбар эрчимтэй хөгжин өргөжин тэлж энэхүү эмчилгээнээс гарсан үр дүнд суурилсан судалгаа шинжилгээ, эмчилгээний чанар хүртээмжийг улам сайжруулах хөгжүүлэх ажлууд өргөн хийгдэж байна. Манай улс эрүүл мэндийн салбарын энэхүү дэвшилтэд шинэ арга технологуудийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн өнгө төрхийг тодорхойлох Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ нь улам бүр өргөжин тэлж, хөгжин шинэ шинэ ололт амжилтууд гарсаар байна. Эмчилгээний шинэ арга технологийг өөрийн орны анагаах ухааны салбарт нэвтрүүлэн олон мянган ард иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг аврах цаашлаад энэ төрлийн эмчилгээг гадаад улс оронд хийлгэхээр явдаг иргэдийнхээ тоог багасгах, явдал чирэгдэл, санхүү эдийн засгийн хүндрэл, гадагшаа чиглэсэн мөнгөний урсгалыг багасгах зэрэг олон асуудлыг шийдэхийн төлөө манай үе үеийн эмч, эрдэмтэн багш, эмнэлгийн мэргэжилтнүүд маань амжилттай ажиллаж байгаа бөгөөд цаашид ч улам илүү ихийг бүтээх, хөгжүүлэх нь дамжиггүй билээ. Энэхүү нарийн төвөгтэй, нүсэр их үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн бичиг баримт биеэ даасан хууль, журамтай болох нь чухал юм.

Баримтлах бодлогын чиг баримжаа:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах гэсэн зорилт дэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал" Алсын хараа 2050 " болон Засгийн газраас 2017 онд баталсан 24 дүгээр тогтоолд " Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилтыг тус тус тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22 өдөр гарсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай тогтоолоор Засгийн газарт Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай болон Цусны донорын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг даалгасан.

Дэлхийн улс орон олон улсын жишиг:

Дэлхийн 93 улс оронд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг ямар нэг хэмжээгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 90 оронд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай биеэ даасан хууль тогтоомж байдаг байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2010 оны 5 дугаар сард хуралдсан 63 дугаар чуулганаар "Resolution WHO 63.22" гэдэг шийдвэр баталсан . Үүнд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлгээ хийж буй улс орнуудад хандан ДЭМБ-аас Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үед баримтлах ерөнхий зарчим заавар гаргаж өгсөн. Энэ нь нийт 11 ерөнхий зарчимтай бөгөөд аливаа улс орон өөрийн орны хууль дүрэм, журамд эдгээр зарчмуудыг тусган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах учиртай юм. Манай улсын одоо хэрэгжиж буй Донорын тухай хууль болон бидний өргөн барьж буй Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хууль маань мөн эдгээр зарчмуудыг дагаж мөрдөн үүний хүрээнд боловсрогдон гарч байгаа болно.

Энэхүү хуулинд хуулийн ерөнхий зарчим, нийтлэг үндэслэл, хуулийн үйл ажиллагааны удирдлага, бүтэц , зохион байгуулалт, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ, эд шилжүүлэн суулгах эмчилгээ, эс шилжүүлэн суулгах эмчилгээний бүлэг болон эрхтэн, эд, эс авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах зэрэг үйл ажиллагааны зохицуулалтуудыг тусгасан нийт 9 бүлэг, ... зүйлтэй байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд нь Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээр хийлгэсэн судалгаа болон АНУ, Турк, БНСУ, ОХУ, Япон, Испани , Энэтхэг, Европын холбооны улсуудын ижил төстэй хууль тогтоомж, журам,

зааврууудыг судалж өөрийн орны нөхцөл байдал одоо хэрэгжиж буй хууль журмуудтай уялдуулан зохицуулан боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:

1. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж үүний хэрээр энэхүү эмчилгээний аргууд улам нэмэгдэж хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
2. Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж нэмэгдэнэ. Гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасаж, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
3. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарна.
4. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинө. Энэ нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулагдах суурь нөхцөл болно.
5. Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах талаар баримтлах бодлого, зохицуулалт улам төгөлдөржин нэгдсэн сүлжээ, тогтолцоо бий болон хөгжиж эмчилгээний төрөл, чанар, хүртээмж, үр дүн илүү сайжирна.

Хууль санаачлагч

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор сайн дураараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомж

2.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Эрүүл мэндийн тухай[2], Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай[3], Эрүүл мэндийн даатгалын тухай[4], Гэр бүлийн тухай[5], Хөдөлмөрийн тухай[6], Нийгмийн даатгалын ерөнхий[7], Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай тухай[8], Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай энэ хууль[8] болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор сайн дураараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбогдох харилцааг зохицуулна.

---

[1]Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

[2]Эрүүл мэндийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

[3]Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

[4]Эрүүл мэндийн даатгалын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

[5]Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

[6] Хөдөлмөрийн тухай "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

[7]Нийгмийн даатгалын ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

[8]Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

3.2.Цусны донортой холбогдсон харилцааг бие даасан хуулиар зохицуулна.

3.3.Эрхтэн, эд, эсийг худалдах, худалдан авах, санал болгох, ашиг олох зорилгоор бусдын болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."хүний эрхтэн, эд, эс" гэж хүний эрхтэн, эрхтний хэсэг, эдийн нийлмэл бүрдэл болон эсийг;

4.1.2."амьд донор" гэж бусдын эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор эрхтэн, эд, эсээ сайн дураар өгөгч гэр бүлийн гишүүн бөгөөд гэрлэгчид, төрлийн хүн, садангийн хүн, хүргэн, бэр гэсэн дараалаар сонгогдсон хүнийг;

4.1.3."амьгүй донор" гэж тархи бүрэн үхжиж, үйл ажиллагаа эргэшгүй алдагдсан, тархины үхэл нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа зарим эрхтэн, эд,эсийг шилжүүлэн суулгахаар авч болох донорыг;

4.1.4."эсийн донор" гэж үүдэл эс болон бэлгийн эсийн донорыг;

4.1.5."тархины үхэл" гэж тархины болон тархины багана хэсгийн үйл ажиллагаа эргэж сэргэхгүйгээр бүрэн алдагдсан байдлыг;

4.1.6."реципиент" гэж донорын эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгуулах зайлшгүй шаардлагатай болон шилжүүлэн суулгуулсан хүнийг;

4.1.7."реципиент эмнэлэг" гэж эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, байгууллагын бүтцэд нь төрөлжсөн тасаг, мэргэжлийн багтай эрүүл мэндийн байгууллагыг;

4.1.8."донор эмнэлэг" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагыг;

4.1.9."үүдэл эс" гэж хуваагдах замаар шинэ эс үүсгэх, ялгаран хөгжих чадвартай эсийг;

4.1.10."хүйн цус" гэж нярайн хүй таслагдсаны дараа ихсийн хүйн судсанд байгаа цусыг;

4.1.11."эд, эсийн сан" гэж эд, эс бүртгэж, шинжилж, өсгөвөрлөж, боловсруулж, хадгалж, шаардлагатай үед эмчилгээ, судалгааны зорилгоор тохирох эд, эсээр хангахыг;

4.1.12.“шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж эмнэлгийн нөхцөлд донорын эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, реципиентэд суулгах мэс засал, эмчилгээг;

4.1.13.“эрхтэн, эд, эсийг авах” гэж донороос эрхтэн, эд, эсийг эмнэлгийн нөхцөлд авахыг;

4.1.14.“эд, эсийн тохироо” гэж донор болон реципиентийн эд, эс удам зүйн шинжээрээ тохирсон байдлыг;

4.1.15.“тээгч эх” гэж бусдын үр хөврөлийг тээж, хүүхэд төрүүлэх эмэгтэйг;

4.1.16.“биологийн эцэг эх” гэж тухайн хүүхдийн удмын мэдээллийг бүрдүүлсэн аав, ээжийг;

4.1.17.“эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ” гэж хүний эрүүл мэнд болон амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хийж буй цогц үйл ажиллагааг;

5 дугаар зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хууль, хүний эрхийг дээдлэх;
5.1.2.хүмүүнлэг, энэрэнгүй байх;
5.1.3.ялгаварлан гадуурхахгүй байх;
5.1.4.хүний эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хамгаалах;
5.1.5.донор нь авлагагүй, сайн дурын байх;
5.1.6.мэдээллийг танилцуулж зөвшөөрөл авсан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
РЕЦИПИЕНТ БОЛОН АМЬД ДОНОРЫГ СОНГОХ, ТЭДГЭЭРИЙН ЭРХ ҮҮРЭГ, АМЬГҮЙ ДОНОРЫГ ИЛРҮҮЛЭХ, БҮРТГЭХ

6 дугаар зүйл.Реципиентэд тавигдах шаардлага

6.1.Реципиентэд дараах шаардлага тавигдана:

6.1.1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх заалт бүхий реципиентийг холбогдох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлсон дүгнэлт, шийдвэр гарсан байх;
6.1.2.реципиент холбогдох журам, зааврын дагуу өөрийн хүсэлтээр үндэсний хүлээх жагсаалтад бүртгэгдсэн байх;
6.1.3.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах зөвшөөрлийг 18 насанд хүрсэн бол өөрөө, хүүхэд бол түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг авсан байх;

6.2. Эрхтэн, эд шилжүүлэн суулгах гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд энэ хуулийн 6.1.1, 6.1.3-т зааснаас гадна дараах шаардлага тавигдана. Үүнд:

6.2.1.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон, тус улсад байнга оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил Монгол улсад хамтран амьдарсан байх, хэрэв гэрлэгчид дундаасаа хүүхэдтэй бол жил харгалзахгүй байх;

6.2.2.Монгол Улсад гадаад улсын иргэн эрхтэн, эд шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх тохиолдолд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн донортой байх.

7 дугаар зүйл.Реципиентийн эрх, үүрэг

7.1.Реципиент доор дурдсан эрх, үүрэгтэй:

7.1.1.яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсрол харгалзахгүйгээр иргэн амьдралын чанараа сайжруулах, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор донорын эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгуулах мэс засал, эмчилгээг хийлгэх;

7.1.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээ, гарч болох эрсдэл, хүндрэлийн талаар мэдээлэл авах;

7.1.3.эмч, эмнэлгийн хяналтад тогтмол үзүүлэх, амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг хүртээмжтэйгээр авах;

7.1.4.эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний өгсөн заавар, зөвлөгөөг дагаж мөрдөх.

8 дугаар зүйл.Амьд донорт тавигдах шаардлага

8.1.Амьд донор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.1.1.21 насанд хүрсэн байх;

8.1.2.энэ хуулийн 4.1.2-д заасан иргэн байх;

8.1.3.гэрлэгч нь гэрлэлтээ бүртгүүлснээс хойш гурваас доошгүй жил болсон байх, хэрэв гэрлэгчид дундаасаа хүүхэдтэй бол жил харгалзахгүй байх;

8.1.4.донор болох шийдвэрээ сайн дурын үндсэн дээр бие даан гаргасан, өөрийн шийдвэрийн эрсдэл, үр дагаврыг бүрэн ухамсарласан, сэтгэцийн эмгэггүй гэдгийг эрх бүхий байгууллага тодорхойлсон байх;

8.1.5.амьд донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө ашгийн төлөө бус авлагагүй сайн дурын байх;

8.1.6. амьд донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд зориулан эрхтэн, эд, эсээ өгөхдөө оршин суугаа газрынхаа хууль хяналтын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлсэн байх;

8.2.Хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авч, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулсан байна.

9 дүгээр зүйл.Амьд донорын эрх, үүрэг

9.1.Амьд донор доор дурдсан эрх, үүрэгтэй:

9.1.1.донорыг яс үндэс, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй байх;

9.1.2.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ, түүнтэй холбоотой бусад мэдээ мэдээлэл авах;

9.1.3.эмч, эмнэлгийн хяналтад тогтмол үзүүлэх, амьдралын чанарыг хангах тасралтгүй тусламж үйлчилгээг хүртээмжтэйгээр авах;

9.1.4.эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөх;

9.1.5.амьд донор болсны төлөө реципиент, түүний гэр бүлийн гишүүдээс аливаа хэлбэрээр ашиг хонжоо, шан харамж авах, шаардахгүй байх.

10 дугаар зүйл.Амьгүй донорт тавигдах шаардлага

10.1.Амьгүй донор тархины үхэл тодорхойлох мэргэшсэн багаар тархины үхэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд эрхтэн, эд, эс авна.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан донорын эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан эцэг, эх, төрсөн хүүхэд, төрсөн ах, эгч, дүү гэсэн дараалаар гэр бүлийн гишүүдийн 3 хүртэлх гишүүнээс зөвшөөрлийг бичгээр авсан байна.

10.3.Амьгүй донорын эрхтэн, эд, эсийг зөвхөн Монгол Улсын иргэнд шилжүүлэн суулгана.

10.4.18 хүртэлх насны амьгүй донорын эрхтэн, эд, эсийг хүүхэд, насанд хүрсэн хүн гэсэн дараалаар шилжүүлэн суулгана.

10.5.Гадны нөлөөтэй амьгүй донороос эрхтэн, эд авах тохиолдолд ажиллах журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүд хамтран батална.

11 дүгээр зүйл.Донор болохоо илэрхийлэх

11.1.21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрхтэн, эд, эсээ бусдад суулгахыг зөвшөөрсөн хүсэлтээ эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар, эсхүл өөрийн биеэр гарын үсэг зурж баталгаажуулан донорын гэрчилгээг авч болно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан донорыг бүртгэх, тэмдэглэгээ хийх, гэрчилгээ олгох журмыг эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн засгын газрын гишүүн хамтран батална.

11.3. Донорын гэрчилгээ эзэмшигч донор болох хүсэлтээсээ татгалзах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

12 дугаар зүйл.Эрхтэн, эд, эс авах

12.1.Амьд донороос эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тохиолдолд энэ хуулийн 8.1-д заасан шаардлага хангасан амьд донороос эрхтэн, эд, эсийг авна.

12.2.Амьгүй донороос эрхтэн, эд, эсийг авах тохиолдолд шилжүүлэн суулгах эрхтэн, эд, эсийн талаар түүний гэр бүлийн гишүүдэд урьдчилан танилцуулж, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно.

12.3.Энэ хуулийн 4.1.8-д заасан заасан эрүүл мэндийн байгууллага нь амьгүй донорыг тодорхойлж, эрхтэн, эд, эс авах бэлтгэлийг хангаж, эрхтэн хамгаалах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.4.Энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэргэжлийн баг эрхтэн, эд, эс авах мэс заслыг гүйцэтгэнэ.

12.5.Амьд болон амьгүй донороос эрхтэн, эд, эс авах, шинжлэх, сонгох, хуваарилах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, хянах, устгах журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

12.6.Үр хөврөлийн болон ургийн үеийн, өдөөгдсөн үүдэл эсүүдийг судалгаа шинжилгээний ажлаас бусад тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

13 дугаар зүйл.Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах

13.1.Донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироо үзэх, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

13.3.Үүдэл эсийг эмчилгээнд ашиглах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

14 дүгээр зүйл.Донорын эрхтэн, эд, эсийг улсын хилээр нэвтрүүлэх

14.1.Эрхтэн, эд, эсийг экспортлохыг хориглоно.

14.2.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу эмчилгээний зорилгоор шаардлага хангасан эд, эсийг импортолж болно.

14.3.Донорын сорьц, эд, эсийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

15 дугаар зүйл.Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд тавигдах шаардлага

15.1.Донор, реципиентийн эрхтэн, эд, эсийн тохироог үзэх, донороос авсан эрхтэн, эд, эсийг шинжлэх, шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээг энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн баг гүйцэтгэнэ.

15.2.Энэ хуулийн 8 дугаар зүйл болон 10 дугаар зүйлд заасан донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг үзүүлнэ.

15.3.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд олон улсын чанарын шаардлагад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгслийг ашиглана.

15.4.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх эд, эсийн сантай байна.

15.5. Эд, эсийн сангийн ажиллах журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

15.6.Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.11-т заасны дагуу төр хариуцна.

15.7.Эс шилжүүлэн суулгах эмчилгээнд үүдэл эсийг ашиглахдаа энэ хуулийн 13.3-д заасан журмыг дагаж мөрдөнө.

15.8.Донор бэлгийн эсийг үр шилжүүлэн суулгах эмчилгээнд ашиглаж болох бөгөөд холбогдох журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

15.9.Эс шилжүүлэн суулгах эмчилгээг энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага эрхэлнэ.

15.10.Эрүүл мэндийн байгууллагаас өөрөө хүүхэд тээх боломжгүй нь батлагдсанаас бусад тохиолдолд тээгч эх ашиглахыг хориглоно.

15.11.Тээгч эхтэй холбоотой тусламж, үйлчилгээг үйлчилгээг энэ хуулийн 15.8-д заасан журмын дагаж мөрдөнө.

15.12.Тээгч эхээс төрсөн хүүхдийн иргэний бүртгэлийг биологийн эцэг, эхийн нэрээр бүртгэнэ.

16 дугаар зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан

16.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай байх бөгөөд мэдээллийн технологийн нууцлал, найдвартай байдлыг хангасан байна.

16.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн ажиллах журмыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

17 дүгээр зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрх

17.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.2.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний талаар баримтлах бодлогыг батлах, биелэлтэд хяналт тавих;

17.1.3.засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

17.1.4.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тогтолцоог бүрдүүлэх, түүнтэй холбогдон гарах зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

17.1.5.дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах;

17.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

18 дүгээр зүйл.Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрх үүрэг

18.1.Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйл ажиллагааны талаар эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах эрх үүрэгтэй:

18.1.1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

18.1.2.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулах, биелэлтийг хангуулах;

18.1.3.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд хяналт тавих;

18.1.4.энэ хуульд заасан холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

18.1.5.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох дүрэм, журам, заавар батлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.6.амьгүй донорыг тандан судлах, илрүүлэх, бүртгэх, эрхтэн, эд, эс хамгаалах эмчилгээ хийх, гэр бүлийн гишүүдээс донор болгох зөвшөөрөл авах бөгөөд энэ хуулийн 12.5-д заасан журмыг дагаж мөрдөнө.

18.1.7.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэргэжилтэн бэлтгэх, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах зардлыг шийдвэрлэх, бодлогоор дэмжиж ажиллах;

18.1.8.энэ хуулийн 4.1.8-д заасан байгууллагын хүчин чадал, чадамжийг сайжруулах, эмч мэргэжилтнийг чадавхижуулах, үйл ажиллагааг дэмжих, ур дүнг тооцох механизм бий болгох;

18.1.9.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн донор эмнэлэг, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах загвар гэрээг батлах;

18.1.10.эд, эсийн сан байгуулах нөхцлийг бүрдүүлэх, нөөцийг бүрдүүлж нөхөн хангалт хийх, бэлэн байдлыг хангах;

18.1.11.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлаар мэргэжил, ёс зүйн хороо ажиллана. Тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.1.12.хуульд заасан бусад эрх, үүрэг.

19 дүгээр зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг

19.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах чиглэлээр:

19.1.1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

19.1.2.донор эмнэлэг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах бөгөөд энэ хуулийн 12.5-д заасан журмыг дагаж мөрдөнө.

19.1.3.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээтэй холбоотойгоор иргэн, эмчлүүлэгч нарт эрсдэл үүсэх, хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

19.1.4.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний явцад донор эмнэлэг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагаас гарч буй зардал, цалин, урамшуулал, илүү цагийн

хөлс зэргийг тооцож төсөв болон гүйцэтгэлийн санхүүжилтэд тусгах саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх;

19.1.5.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ажиллуулах;

19.1.6.үндэсний хүлээх жагсаалтад реципиентийг бүртгэх.

19.2.Сургалт, судалгаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

19.2.1. эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, дүн шинжилгээ судалгаа хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

19.2.2.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллага болон төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах; эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, багийн чадавхийг дээшлүүлэх,

19.2.3.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, ухуулан таниулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

19.2.4.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд орчин үеийн шинэ технологи, арга аргачлалыг нэвтрүүлэх, иргэдийг эх орондоо эмчлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх талаарх үйл ажиллагааг дэмжин ажиллах.

19.3.Амьгүй донорыг илрүүлэх, эрхтэн, эд, эс хуваарилах, зохицуулах чиглэлээр:

19.3.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан байгууллагад амьгүй донорыг илрүүлэх, тархины үхэл тодорхойлох багт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

19.3.2.улсын хэмжээнд амьгүй донорын тандалт хийх, илрүүлэх, бүртгэх тогтолцоог удирдан зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, хяналт тавьж хамтран ажиллах;

19.3.3.амьгүй донорын гэр бүлтэй уулзах, эрхтэн, эд, эсийн донор болгох хүсэлт тавих;

19.3.4.амьгүй донорыг бүртгэх, сонгох, шинжлэх, нийлүүлэх, хуваарилах, хадгалах, тээвэрлэх, хянах үйл ажиллагааг гүйцэтгэх бөгөөд энэхүү жрумыг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батлана;

19.3.5. Энэ хуулийн 18.1.9 заасан заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

19.4.Ёс зүй, олон нийттэй харилцах чиглэлээр:

19.4.1.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, донор эмнэлгийн, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьж Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, 26.5-д заасан ёс зүйн хороодтой хамтран ажиллах;

19.4.2.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх;

19.4.3. хүний наймаа болон хүний эрхтэн, эд, эсийн наймаатай холбоотой аливаа хууль зөрчсөн үйлдлийн талаар холбогдох хууль хяналтын байгууллагад мэдэгдэх;

19.4.4.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, ухуулан таниулах, ойлгуулах үйл ажиллагааг боловсролын болон хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

19.5.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

20 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын нийтлэг чиг үүрэг

20.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, энэ хуулийн 4.1.7-д заасан эрүүл мэндийн байгууллага байх ба тус байгууллагын бүтцэд мэргэжлийн баг, нэгж ажиллана.

20.2.энэ хуулийн 4.1.6, 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллага нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний болон амьд, амьгүй донорын талаарх мэдээллийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр үнэн зөв мэдээлнэ.

20.2.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.1.амьд донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх, хяналт тавих;

20.2.2.реципиентэд тавих нөхцөл, шаардлага, үзүүлэлт хангасан хүнийг үндэсний хүлээх жагсаалтад бүртгүүлэхээр энэ хуулийн 20-д заасан байгууллагад мэдээллэх;

20.2.3.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг энэ хуулийн 19.1.5-д заасан санд тухай бүр оруулах;

20.2.4.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг эрх бүхий байгууллагаас батлагдсан журам, заавар, стандарт, технологийн дагуу гүйцэтгэх;

20.2.5.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах;

20.2.6.эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэн бэлтгэх, сургах, хүний нөөцийг чадавхжуулах;

20.2.7.эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний явцад тохиолдож болох хүндрэл, эрсдэлээс сэргийлэх;

20.2.8.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд орчин үеийн шинэ технологи, арга аргачлалыг нэвтрүүлэх;

20.2.9.амьд донор болон реципиентэд урт хугацаанд хяналт тавих;

20.2.10.аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн зохих эмнэлгийн мэргэжилтэнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулах;

20.2.11.хуульд заасан бусад.

20.3.энэ хуулийн 4.1.8-д заасан эрүүл мэндийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.3.1.эрүүл мэндийн байгууллагын бүтцэд тархины үхэл тодорхойлох мэргэшсэн баг ажиллуулах;

20.3.2.амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах;

20.3.3.амьгүй донор эмчлүүлж буй төв, тасаг, нэгжийн эм, эмнэлгийн хэрэгсэл болон бэлэн байдлыг хангах;

20.3.4.амьгүй донорын талаарх мэдээллийг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан байгууллагад тухай бүр мэдээлэх;

20.3.5.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагаас ажиллах багийн үйл ажиллагааг дэмжин ажиллах, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх;

20.3.6.тухайн эрүүл мэндийн байгууллагад донорын эрхтэн, эд, эсийг авах мэс заслыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд амьгүй донорын эрчимт эмчилгээг үргэлжлүүлэх, зөөвөрлөх бэлэн байдлыг хангуулах талаар энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан байгууллагатай хамтран ажиллах;

20.3.7. Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах мэс засал, эмчилгээнд оролцож байгаа болон реципиентийн эмчлэгч эмчийг тархины үхэл тодорхойлох мэргэжлийн багийн бүрэлдэхүүнд орохыг хориглоно.

21 дүгээр зүйл.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд хориглох зүйл

21.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд дараах үйл ажиллагааг хориглоно:

21.1.1.Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ гүйцэтгэхэд оролцсон эмнэлгийн мэргэжилтэн нь донор болон реципиент, тэдний гэр бүлийн гишүүн, тэдгээрийн хамаарал бүхий этгээдээс аливаа хэлбэрээр төлбөр, урамшуулал авах;

21.1.2.Донор болон реципиентийн эмзэг мэдээллийн нууцыг хадгалж, өөрөөс нь бусдад мэдээлэх, задруулах, дамжуулах;

21.1.3.Шинжлэх ухааны бус зориулалтаар судалгаа шинжилгээ, туршилт хийхээр эсийн эмчилгээний үеийн дэвшилтэт биотехнологийн аргуудыг ашиглах;

21.1.4.Эмнэлгийн мэргэжилтэн нь эрхтэн, эд, эсийн донорыг зуучлах, сурталчлах, худалдах, санал болгох, бусдад давуу эрх олгох;

21.1.5.Донорын эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд оролцож байгаа буюу реципиентийг эмчилж байгаа эмнэлгийн мэргэжилтэн энэ хуулийн 20.3.1-д заасан багийн бүрэлдэхүүнд орох.

22 дугаар зүйл.Амьд донорын нийгмийн баталгаа

22.1.Амьд донор дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

22.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговорыг хөдөлмөрийн чадвар алдсан хугацаандаа авах;

22.1.2.донор нь эрхтэн, эд, эсээ өгөхдөө тухайн тусламж, үйлчилгээг гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулах, заавал даатгуулах болон бусад даатгалд хамрагдах;

22.1.3.эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний явцад эсхүл, дараа нь уг эмчилгээний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43.5-д заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг тогтоолгох;

22.1.4.эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний явцад технологийн заавар зөрчигдсөний улмаас донорын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон бол эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгасан буруутай этгээд, байгууллагаар хохирлоо нөхөн төлүүлэх;

22.1.5. амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

22.1.6.хуульд заасан бусад эрх.

23 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж

23.1.Амьгүй донор болсон иргэний гэр бүлд дор дурдсан тэтгэмж олгоно

23.1.1.Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхээс үл хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын зардал.

23.2. Амьгүй донорт хүндэтгэл үзүүлэх, алдаршуулах үйл ажиллагааг энэ хуулийн 12.5-д заасан журмаар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл. Санхүүжилтийн тогтолцоо

24.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулах, ухамсарлуулах нөлөөллийн үйл ажиллагаа, донорын үйл хэрэг, шилжүүлэн суулгах, эрчимт эмчилгээ, хяналт, судалгаа шинжилгээ, сургалт, эс, эдийн сан байгуулах, хадгалах, тээвэрлэх, мэдээллийн сан үүсгэх, үр дүнг тооцохтой холбоотой санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

24.2.Донорын эрхтэн, эд, эсийг эмчилгээний зориулалтаар авах, шилжүүлэн суулгах үйл ажиллагааны санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр, Засгийн газрын тусгай сан, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

24.3. Энэ хуулийн 4.1.6, 4.1.8 дахь заалт, 19 дүгээр зүйлд заасан байгууллага нь амьгүй донор илрүүлэх үйл ажиллагаа, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний зардал, цалин, урамшуулал, илүү цагийн хөлс зэргийг тооцож төсөв болон гүйцэтгэлийн санхүүжилтэд тусгах саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

24.4. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг үнийн өсөлт, инфляцийн түвшин, валютын ханшийн зөрүүтэй уялдуулан эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.5. Энэ хуулийн 20-д заасан байгууллага нь гадаад улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ авч буй иргэд, тэдгээрийн гэр бүлээс гарч буй зардал, санхүүгийн тоо мэдээ, мэдээллийг нэгтгэн гаргаж эрүүл мэндийн болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

24.6.Дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцна.

25 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

25.1.Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага хяналт тавина.

26 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....дугаар
сарын....-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын иргэний бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.18, 6.19 хэсэг:

"6.18.Тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг түүний биологийн эцэг, эхийн овог нэрээр бүртгэж төрсний гэрчилгээг олгоно.

6.19.Тээгч эхээс төрсөн хүүхдийн төрсний бүртгэлийг хийх журмыг Бүртгэлийн асуудал хариуцсан газрын дарга, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална."

2/6дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

"6.1.4.хүүхэд тээгч эхээс төрсөн бол түүнийг нотлох эмнэлгийн байгууллагын магадлагаа, холбогдох баримт бичиг."

2 дугаар зүйл.Улсын иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар үзүйлийн 6.1 дэх хэсгийн "хүүхэд" гэсний өмнө ", тээгч эхээс төрсөн хүүхдийн биологийн эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч" гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....дугаар сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"8.4.Эрхтэн,эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн 23.1.1-д заасан донорын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхээс үл хамааран гэр бүлийн гишүүнд нь тэтгэмж олгоно.

8.5.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....дугаар
сарын....-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

“24.6.11. Хүүхдэд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....дугаар
сарын....-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.10 дугаар зүйлийн гарчигийн, 2 дахь хэсгийн "донорын" гэснийг "эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах" гэж , 3, 4, 6 дахь хэсгийн "эс, эд, эрхтнийг" гэснийг "эрхтэн, эд, эсийг" гэж, 5 дахь хэсгийн "Донорын эрхтэн, эд, эсийг экспортолсон, эсхүл шаардлага хангахгүй эд, эсийг" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....дугаар сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Донорын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨГСӨН САНАЛ

№	Өгсөн санал	Тайлбар
1	Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.12-т "Энэ хуулийн 22.1.3-т заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана." гэж заасан. Иймд хуулийн төслийн нэрийг өөрчилж байгаа талаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.12-т заасны дагуу үзэл баримтлалд тусгах шаардлагатай.	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль нь анхдагч хуулийн төсөл бөгөөд энэхүү хуулиар Донорын тухай хууль нь хүчингүй болгохоор тусгасан байгаа. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.12-т заасны дагуу дурдах шаардлагагүй гэж үзсэн тул саналыг тусгаагүй.
2	Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар хуулийн төсөлтэй хамт Донорын тухай хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 6.10 дугаар зүйлд заасан Донорын тухай хууль зөрчих гэсэн зохицуулалтад өөрчлөлт орохоор байгааг анхаарах, мөн хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хуулийн төсөлтэй хамт боловсруулах хуулийн төслийг ирүүлээгүй байх ба хууль хоорондын зөрчил үүсгэхгүй байх үүднээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.3-т заасан "... бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна." гэж заасны дагуу дагалдах хуулийн төслийг хамтад нь боловсруулах нь зүйтэй.	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль дагаж гарах хуулийн төслийг боловсруулсан бөгөөд эдгээр хуулийн нэг болох Зөрчлийн тухай хуулийн 6.10-г өөрчлөлт оруулсан байна.
3	Хуулийн төсөлд "эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага", "эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж зөрүүтэй томьёолсныг нэг мөр болгох, түүнчлэн, төслийн 18.1.5 болон 19.1.4-т эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг байгуулах, байгууллагын дүрэм, бүрэлдэхүүнийг батлах бүрэн эрхийг Засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад буюу өөр өөр этгээдэд олгохоор тусгасан байна.	Хуулийн төсөлд "эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэсэн томьёололоор явж байгаа тул дээрх саналыг тусгасан. Төслийн 18.1.5, 19.1.4-т тусгасан. 18.1.5-ыг зассан.

4	Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн үйлчлэлд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын тооцооны тайланд тусгайлсан агентлаг шинээр байгуулах замаар бүтэц, орон тоо, цалин хөлс, үйл ажиллагааны бусад урсгал зардлыг 1.9 тэрбум төгрөг байхаар тодорхойлсон нь төсвийн зардлыг нэмэгдүүлэх үр дагавартай байна. Иймд Төсвийн тухай хуулийн 6.2.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх" гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно." гэж тус тус заасны дагуу холбогдох тооцоо судалгааг гаргаж, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтийг боловсруулах.	Шинээр байгуулагдах байгууллагын зардлыг тооцоо, судалгааг Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу хийгдсэн байна.
5	Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар Монгол Улс 2018 онд Испанийн Хаант Улсад болсон дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэгийн 27 дугаар их хурлын үеэр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний үед хүний наймаа, хүний эс, эд, эрхтний наймаа, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг хамтран ажиллах тунхаглал буюу Станбулын тунхаглалд гарын үсэг зурж, элсэн орсон, мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээ хийж буй улс орнуудад хандан гаргасан "донорын эрхтэн, эд, эсээр өөрийн орны хэрэгцээг хангах, эрхтэн, эд, эсийг өөр орон руу дамжуулах, худалдан наймаалцах үйл ажиллагааг хязгаарлах" зарчим, зөвлөмжтэй хуулийн төслийн 3.3 дахь хэсэг нийцэхгүй байгааг анхаарч, төслөөс хасах. Түүнчлэн, хуулийн төслийн 15 дугаар зүйлд донорын эрхтэн, эд, эсийг улсын хилээр нэвтрүүлэх зохицуулалтыг тусгасан байх бөгөөд олон улсад, тухайлбал Европын холбооны туршлагаар донороос зөвшөөрөл авах, эрхтэн, эд, эсийн чанар, аюулгүйн шаардлагын асуудлаар холбогдох байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцохыг Европын зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2012/25/EU тогтоолд дэлгэрэнгүй заасан байдаг. Тус асуудал нь хүний эрхтэн, эд, эсийн наймааны үндэстэн дамнасан гэмт хэргийн тоо өсөх, гарал үүсэл тодорхойгүй, эрүүл мэндийн шаардлага хангаагүй орчин, нөхцөлд эрхтэн, эд, эсийг тээвэрлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүйг анхаарч, хуулийн төсөлд нарийвчлан тусгах.	Хуулийн төслийн 3 дугаар зүйл нь хуулийн үйлчлэх хүрээг тусгасан бөгөөд 3.3 дахь хэсэг нь бусад харилцааг холбогдох хууль буюу Эрүүгийн хуулиар зохицуулахаар тусгасан байна. Хуулийн төслийн 14 дүгээр зүйл нь Донорын эрхтэн, эд, эсийг улсын хилээр нэвтрүүлэх харилцааг зохицуулсан бөгөөд 14.1 дэх хэсэгт "Эрхтэн, эд, эсийг экспортлохыг хориглоно." гэж тодорхой заасан байгаа. Мөн хуулийн төслийн 14.2 дахь хэсэгт эд, эсийг импортлох харилцааг зохицуулсан бөгөөд "Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу эмчилгээний зорилгоор шаардлага хангасан эд, эсийг импортолж болно." гэж заасан. Энэхүү харилцааг зохицуулах журмыг хуулийн төслийн 14.3 дахь хэсгээр батална. Жишээ нь: нүдний эвэрлэг(эд)-ийг АНУ-аас импортолж олон хүнд хараа оруулах эмчилгээг хийж байна.

6	Хуулийн төслийн 4.1.7-д "реципиент эмнэлэг" гэж эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусгай зөвшөөрөлтэй, байгууллагын бүтцэд нь төрөлжсөн тасаг, эсхүл мэргэжлийн багтай эрүүл мэндийн байгууллагыг гэж тодорхойлж, хуулийн төслийн 14.1, 16.1, 16.9-д тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны талаар тусгахын зэрэгцээ эдгээр зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээдтэй холбоотой зохицуулалт хуулийн төсөлд тодорхойгүй байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төрөлд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд мөн хуулийн 9.1 болон 9.3 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрөл шинээр бий болгох, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаарх дүгнэлтийг Ерөнхий сайдын дэргэдэх орон тооны бус зөвлөл гаргах зохицуулалттай болохыг анхааарч, зөвшөөрлийн асуудлаар уг зөвлөлөөс дүгнэлт гаргуулах.	Реципиент эмнэлгийн тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн яамнаас олгож байгаа бөгөөд тус хуулиар аливаа төрлийн тусгай зөвшөөрлийг шинээр бий болгохгүй.
7	Хуулийн төслийн 11.1, 12.2, 13.5, 14.2, 14.3, 15.3, 16.5, 16.10, 16.12, 17.2, 19.1.6, 19.1.7, 20.1.2, 20.1.5, 23.1.5, 24.2-т тодорхой төрлийн харилцааг захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулахаар эрх олгосон заалтуудыг тусгажээ. Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд заасны дагуу хуулиар Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгосон заалтыг 2 дахин багасгах чиглэлийг баримтлан холбогдох хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэ хүрээнд үлгэрчилсэн загвар, аргачлал, маягт зэрэг хуульд тусгахад хүндрэлтэй, тухайн харилцааг тухай бүр зохицуулах боломжгүйгээс бусад эрх зүйн үр дагавар үүсгэх, хуульчлах боломжтой харилцааг хуульчлах чиглэлийг баримтлахад анхаарах.	Хуулийн төслийн 11.2 (12.2), 12.5 (13.5), 13.3 (14.3), 14.3 (15.3), 15.5 (16.5), 16.2 (17.2), 19.1.5 (20.1.5), 22.1.5 (23.1.5) дахь хэсгийг хэвээр үлдээж, 11.1, 16.10, 19.1.7, дэх хэсгийг хасаж, 13.2 (14.2) дахь хэсгийг "...энэ хуулийн 12.5-д заасан" гэж, 15.7 (16.7) дахь хэсгийг "...ашиглахдаа энэ хуулийн 13.3-д заасан журмыг дагаж мөрдөнө." гэж, 15.8 (16.8) дахь хэсгийг "...ашиглаж болох бөгөөд холбогдох журмыг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална." гэж, 15.12 (16.12) дахь хэсгийг "...үйлчилгээг энэ хуулийн 15.8 (16.8)-д заасан журмын дагаж мөрдөнө." гэж, 18.1.6 (19.1.6) дахь хэсгийг "...энэ хуулийн 12.5-д заасан" гэж, 19.1.2 (20.1.2) дахь хэсгийг "...энэ хуулийн 12.5-д заасан" гэж, 23.2 (24.2) дахь хэсгийг "...энэ хуулийн 12.5-д заасан" гэж тус тус саналыг тусгасан.

8	Монгол Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хүчин төгөлдөр бус болсон Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай холбогдуулан хуулийн төсөлд туссан зохицуулалтуудыг дээрх хуулиудад нийцүүлэх.	Хуулийн төслийн 2.1 дэх хэсэгт "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Гэр бүлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгал ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ." гэж саналыг тусгасан.
9	Хуулийн төслийн 4.1.2-т донор болох үйл ажиллагааг хэт сунжруулж, цаг хугацааны хувьд удаашрах үр дагавартай байх тул тус заалтын "бэр гэсэн дараалаар сонгогдсон хүнийг" гэснийг "бэр, эсхүл энэ хуулийн 12.1-д заасан донор болохоо илэрхийлсэн хүнийг" гэж өөрчлөх.	Хуулийн төслийн 4.1.2 дахь хэсэгт амьд донорыг тодорхойлсон бөгөөд 12.1 дэх хэсэг нь амьгүй донортой холбоотой үйл ажиллагаа тул саналыг тусгах боломжгүй.
10	Хуулийн төслийн 4.1.8-д "донор эмнэлэг"-ийг тодорхойлж, мөн төслийн 21.3-т донор эмнэлгийн чиг үүргийг заасан байх боловч тухайн байгууллага нь ямар статустай байгууллага болох нь хуулийн төсөлд тодорхойгүй байгааг анхаарах.	Хуулийн төслийн 4.1.8-д "Донор эмнэлэг гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагыг;" гэж саналыг тусгасан.
11	Хуулийн төслийн 6.2 дахь хэсгийг "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 6.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангана:" гэж өөрчлөн найруулах.	Хуулийн төслийн 6.2 дахь хэсэгт "Эрхтэн, эд шилжүүлэн суулгах гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 6.1.1, 6.1.3-т зааснаас гадна дараах шаардлага тавигдана. Үүнд:" гэж саналыг тусгасан.
12	Хуулийн төслийн 8, 10 дугаар зүйлд заасан амьд болон амьгүй донорт тавигдах шаардлагад донор нь гэмт хэргийн хохирогч болсон байх үндэслэл, сэжиг илэрсэн тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шалгуулах, мөн донорын талаарх мэдээллийн сан үүсгэх, ашиглах талаар зохицуулалт нэмэх.	Хуулийн төслийн 8, 10 дугаар зүйл нь Амьд болон амьгүй донорт тавигдах шаардлага тул энэ хэсэгт оруулах шаардлагагүй.

13	Хуулийн төслийн 8.2-т "Хүүхдээс ясны хэм, захын цус авахдаа 14 хүртэлх настай бол эцэг, эх болон асран хамгаалагчийн, 14-өөс дээш настай бол өөрийнх нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байна" гэж заасан нь Иргэний хуулийн 15.1-д "Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэний өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно" гэж, мөн хуулийн 16.1-д "Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна" гэж, 16.3.2-т "насанд хүрээгүй этгээд өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хийх" гэж тус тус заасантай нийцэхээргүй байгаа тул "14-өөс дээш настай бол өөрийнх нь зөвшөөрлийг бичгээр авахаар" гэж заасныг дахин нягтлах.	Иргэний хуулийн 16.1-т "Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна" гэж заасан нь 14-18 насны хүүхэд бүрэн бус чадамжтай байх тул өөрөөс нь болон эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг бичгээр хамтад нь авна. Учир нь дан ганц эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн зөвшөөрлийг харгалзан үзэх нь бүрэн бус чадамжийг бүрэн илэрхийлж чадахгүй гэж үзсэн тул тухайн хүүхдийн өөрийн саналыг харгалзан үзэх нь зөв болно. Мөн донор нь дан ганц гэр бүл бус өөрөө бие даан шийдвэр гаргасан байх ёстой байдаг.
14	Хуулийн төслийн 9.1.5 дахь заалтад "аливаа хэлбэрээр ашиг хонжоо, шан харамж авахгүй, шаардахгүй байх" гэж тодотгож тусгах.	Хуулийн төслийн 9.1.5 дахь хэсэгт "амьд донор болсны төлөө реципиент, түүний гэр бүлийн гишүүдээс аливаа хэлбэрээр ашиг хонжоо, шан харамж авах, шаардахгүй байх." гэж саналыг тусгасан.
15	Хуулийн төслийн 10.1-д "Амьгүй донор нь тогтоогдсон тохиолдолд эрхтэн, эд, эс авна." гэснийг "Амьгүй донор нь эмнэлэг, эмчийн магадлагаагаар тогтоогдсон тохиолдолд түүний эрхтэн, эд, эсийг авна." гэж өөрчлөн найруулах.	Хуулийн төслийн 10.1 дэх хэсэгт "Амьгүй донор нь энэ хуулийн 20.3.1–д заасан багаар тархины үхэл нь тогтоогдсон тохиолдолд эрхтэн, эд, эс авна." гэж саналыг тусгасан.
16	Хуулийн төслийн 12.1 дэх хэсэгт тусгасан "... эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад..." гэснийг Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын аль нь болохыг тодорхой тусгах. Түүнчлэн, мөн зүйлийн 12.3-т "Донорын гэрчилгээ эзэмшигч донор болох хүсэлтээсээ татгалзах эрхтэй" гэснийг "Донорын гэрчилгээ эзэмшигч донор болох хүсэлтээсээ мэс засал товлогдсон өдрөөс өмнө хэдийд ч татгалзах эрхтэй." гэж өөрчлөн найруулж, мөн донор болохоос татгалзахтай холбоотой хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.	Хуулийн төслийн 11.1 (12.1) дэх хэсэгт "21 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрхтэн, эд, эсээ бусдад суулгахыг зөвшөөрсөн хүсэлтээ Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар, эсхүл өөрийн биеэр гарын үсэг зурж баталгаажуулан донорын гэрчилгээг авч болно." гэж өөрчлөн тусгасан.

17	Хуулийн төслийн 13 дугаар зүйлд "Энэ хуулийн 13.4-т заасны дагуу мэргэжлийн баг, эрхтэн, эд, эс авах мэс заслыг гүйцэтгэсний дараа амьгүй донорын гэр бүлийн гишүүдэд шилжүүлэн авсан эрхтэн, эд, эсийн талаар танилцуулах бөгөөд энэ хуулийн 13.2-т заасны дагуу танилцуулснаас бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно." гэх агуулга бүхий зохицуулалт нэмэх.	Хуулийн төслийн 12.2 (13.2) дахь хэсэгт "Амьгүй донороос эрхтэн, эд, эсийг авах тохиолдолд шилжүүлэн суулгах эрхтэн, эд, эсийн талаар түүний гэр бүлийн гишүүдэд урьдчилан танилцуулж, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан донороос авах бөгөөд зөвшөөрснөөс бусад эрхтэн, эд, эсийг авахыг хориглоно." гэж саналыг тусгасан.
18	Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг "Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалт"-д туссан Засгийн газрын бүрэн эрх, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан эрхлэх асуудал, бүрэн эрх, чиг үүрэгт нийцүүлэх шаардлагатай байна.	Нийцүүлсэн.
19	Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1-д "Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эмнэлгийн мэргэжилтний болон анагаах ухааны Ёс зүйн хяналтын хороо, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дэргэд ёс зүйн салбар хороо, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, тусгай мэргэжлийн төвийн дэргэд Анагаах ухааны ёс зүйн хяналтын салбар хороо тус тус ажиллана." гэж, мөн зүйлийн 26.5-д "Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлаар мэргэжил, ёс зүйн хороо ажиллана." гэж тус тус заасан тул хуулийн төслийн 20.4-т туссан ёс зүйн хороог Эрүүл мэндийн тухай хуульд нийцүүлэн уг хуулиас эшлэх байдлаар тодорхой тусгах.	Хуулийн төслийн 19.4.1 (20.4.1) дэх хэсэгт "эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, донор эмнэлгийн, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьж Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, 26.5-д заасан ёс зүйн хороодтой хамтран ажиллах;" гэж, 19.4.2 (20.4.2) дахь хэсэгт "эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх;" гэж тус тус саналыг тусгасан.
20	Хуулийн төслийн 21.2.9-д "амьд донор болон реципиентэд урт хугацаанд хяналт тавих" гэж заасныг "амьд донор болон реципиентэд насан туршид нь хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авах" гэх байдлаар ямар хугацаанд, ямар хяналт тавихыг тодорхой тусгах.	Тусгах шаардлагагүй. Энэхүү харилцааг хуулийн төслийн 12.5-д заасан журмаар зохицуулна.

21	Хуулийн төслийн 24.1.1-д дурдсан тэтгэмжийг хэн, хэрхэн олгох талаар зохицуулалт хуулийн төсөлд тодорхойгүй байгааг анхаарч, нарийвчлан тусгах.	Хуулийн төслийн 23.1.1 (24.1.1) дэх хэсэгт заасан тэтгэмжийг хууль дагаж гарах Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар дагаж зохицуулна.
22	Хуулийн төслийн 25 дугаар зүйлд туссан санхүүжилтийн тогтолцоо хэт ерөнхий байдлаар туссан байгааг нарийвчлан тодорхой тусгах. Түүнчлэн, мөн зүйлийн 25.1-д эс, эдийн банк байгуулахтай холбоотой санхүүжилтийн талаар туссан байх бөгөөд эс, эдийн банк, түүнийг байгуулахтай холбоотой зохицуулалт хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн бусад хэсэгт тусгагдаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.1-д "Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна." гэж заасантай нийцэхгүй байх тул хуулийн төслөөс хасах.	Эд, эсийн банк нь олон удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд нэр томьёоны хувьд эд, эсийн сан хэмээн тодорхойлох нь оновчтой хэмээн үзэж нэр томьёоны хувьд өөрчлөлт орсон. Эд, эсийн сан нь үзэл баримтлал болон хуулийн төсөлд тусгагдсан болно.
23	Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.1-д "Хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэнэ." гэж заасны дагуу хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргаагүй байгааг анхаарах.	Дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж хавсаргав.
24	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3.9-д хуулийн төслийн бүтцэд "шаардлагатай бол хууль хүчин төгөлдөр болох тухай хэм хэмжээ"-г тусгахаар заасан тул хуулийн төсөлд хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгах эсэхийг нягтлах.	Тусгах шаардлагагүй.
25	Хуулийн төсөлд дурдсан "амьдралын чанар", "биологийн эцэг, эх" гэсэн нэр томьёог нарийвчлан тодорхойлох, түүнчлэн хуулийн төсөл нийтлэг байдлаараа үг үсэг, эшлэл, агуулгын алдаа, хууль зүйн техникийн болон найруулга зүйн алдаатай байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийг боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг хангаагүй байгааг анхаарах." гэжээ.	Хуулийн төслийн 4.1.16 дахь хэсэгт "биологийн эцэг эх" гэж тухайн хүүхдийн удмын мэдээллийг бүрдүүлсэн аав, ээжийг;" гэж саналыг тусгасан. Монгол улсын бусад хууль тогтоомжид амьдралын чанарыг тодорхой тайлбарлаж тусгаагүй байдаг бөгөөд амьдралын чанар гэх нэр томьёог нарийвчлан тодорхойлох шаардлагагүй байна.

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн бүтэц, зохицуулалтуудыг шинээр боловсруулах, хуучин байсан Донорын тухай хуулийн зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгох, тодорхойгүй байгаа зүйл заалтуудыг шинээр тодорхой болгож , шинээр байгуулагдах Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах төвийн бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн төлөөллийг нарийн тусгах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг оролцуулах, эмчилгээ үйлчилгээний шалгуур үзүүлэлт, арга аргачлал, журмыг гаргах нөхцөл боломжийг бүрдүүлэх байдлаар боловсруулсан энэхүү хуулийн төслийн үр нөлөөг судлахад оршино.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан " Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал " / Цаашид "Аргачлал" гэх/ -д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах, хэрэгслэлийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖИЛЛАГАА

2.1. ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын "Донорын тухай" хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2018, 2021,2022 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулиар хүний эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дурааараа цус, эд, эрхтэнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эс, эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, донорын үйлсийг таниулан ойлгуулах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийг найруулах болсон шалтгаан нь анагаах ухааны практикт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ технологи нэвтэрч эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр иргэдийн дунд эрхтэн, эд, эс

шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх шаардлагатай эрхтэн тогтолцооны өвчин эмгэгтэй иргэдийн тоо нэмэгдэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, элэг, бөөрний эмгэг, хорт хавдар, осол гэмтэл орж байна. 2018 онд шинэчлэгдэн батлагдсан Донорын тухай хууль болон дагаж мөрдөх журмуудыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны явцад энэхүү хуулийг Цусны донорын хуулинаас салган биеэ даасан эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль болгон өөрчлөн хамрах хүрээг өргөжүүлэх, энэхүү эмчилгээ үйлчилгээний нарийн төвөгтэй, онцлог зүйлсийг багтаасан эрх зүйн зохицуулалт хийх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хуулийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг амьд болон амьгүй донороос хийх бөгөөд эдгээр эмчилгээ үйлчилгээг тус бүрд тодорхой бүлэг болгон хуулийн төсөлд оруулах юм. Учир нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний ерөнхий зарчим нь өвчин эмгэгтэй хүний өвдсөн эрхтэн, эд, эсийг эрүүл эрхтэн, эд, эсээр орлуулах, шилжүүлэн суулгаж эмчилгээ хийх боловч өөр өөрийн онцлог, биеэ даасан ялгагдах өвөрмөц арга барил, нарийн технологитой цогц үйл ажиллагаа байдаг билээ. Иймд бүлэг тус бүрт заагдсан заалтууд энэхүү нарийн асуудлуудын хооронд үүсэх харилцаа, учир холбогдлыг зохицуулах ёстой юм. Хуулийн төсөлд амьд болон амьгүй донорын насны хязгаарыг өргөтгөх ,ТҮД-ын гэр бүлд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох, амьд донорын гэр бүлийн гишүүдийн донор болох боломжийг нэмэгдүүлэх, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй донор эмнэлэг болон эрхтэн шилжүүлэн суулгах эмнэлгүүд, тэдгээрийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцлийг дээшлүүлэх, дэмжих, эдийн засгийн хөшүүрэг цалин хөлс, илүү цагийн нэмэлт, урамшууллын тогтолцоог тодорхой болгох, эмнэлгээс гарч буй зардлыг тохиолдолд суурилсан тооцоо буюу гүйцэтгэлээр тооцоог улсын төсөв, ЭМД сангаас санхүүжүүлэх зэрэг үзүүлэлтүүдийг сонгож байна. Түүнчлэн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож шинэ түвшинд гаргах бөгөөд эдгээрийг өөрчлөлтүүдийг хуульд суулгаж өгч үйл ажиллагаанд хэрэгжүүлж чадсанаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний бодит үр дүн, тоо, чанар улам дээшилж олон хүний амь нас эрүүл мэндийг аврах боломж нэмэгдэн, гадаад улс оронд энэ чиглэлээр эмчилгээнд явах иргэдийн тоо буурах, гадагш урсах мөнгөний урсгал буурна. Мөн шинэ тутам үүсэн хөгжиж буй үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах цаашлаад эс, эдийн банк байгуулах эс, эдийг хадгалах, өсгөвөрлөх, ургуулах, тохируулах инжинерчлэл хийдэг болох юм. Ингэснээр одоогоор эмчлэгдэж чадахгүй байгаа олон өвчин эмгэгийг эмчлэхэд ашиглаж болох боломж бүрдэнэ. Клиник практикийн үр дүнд суурилсан судалгаа, шинжилгээг өргөжүүлэхэд хуулийн үр нөлөө ихээхэн ач холбогдолтой байх болно.Нөхөн үржэхүйн чиглэлд үр шилжүүлэн суулгах, тээгч эхийн талаар баримтлах бодлого, эрх зүйн харилцааг боловсронгуй болгож шинээр хуулийн төсөлд оруулан шийдвэрлэж үр дүн, ач холбогдол үр нөлөөг нь үнэлж тооцох юм.

2.2 Үр нөлөөг тооцох хэсэг

Хуулийн шинэ төсөлд санал болгож буй бүхий л асуудлууд нь үр нөлөөг тооцоход нэн чухал, салшгүй хэсэг байх ба хуулийн гол үзэл санаа нэмэлт өөрчлөлтүүд болон шинээр тусгагдаж буй зохицуулалтууд орсноор Амьгүй болон амьд донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний цар хүрээ нэмэгдэж үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоо улам боловсронгуй, илүү далайцтай болж хөгжсөнөөр эрхтэн, эд, эсийн тогтолцооны эмгэгийн эцсийн үе шатанд байгаа олон эмчлүүлэгчдийн амь нас, эрүүл мэндийг аврах бодит нөхцөл бололцоог нэмэгдүүлнэ. Ингэснээр одоогоор эх орондоо эмчилж чадахгүй байгаа олон эмгэг өвчинг эмчилдэг болох цаашлаад гадаад улс орон руу ийм төрлийн эмчилгээ үйлчилгээнд явах иргэдийнхээ явдал чирэгдэл, санхүүгийн болон сэтгэл санааны дарамтыг арилгаж гадагшаа чиглэсэн мөнгөний урсгалыг багасгана. Мөн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсноор манай улс руу энэ төрлийн эмчилгээ үйлчилгээг авах зорилгоор ирэх гадаад улсын иргэдийн тоо нэмэгдэх юм.

Түүнчлэн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тусламж үйлчилгээнд оролцож буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ДЭМБ-аас дэвшүүлсэн (Resolution WHO 75. 2022) 11 зарчим болон 2018 онд шинэчлэгдэн батлагдсан Истанбулын тунхаглалын (Stanbul Decloration 2018) үзэл санааг үйл ажиллагаандаа баримтлан хуулийн хүрээнд , ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажил үүргээ гүйцэтгэнэ.

2.3 Үр дүнг үнэлэх

Хуулийн төслийн үр дүнг үнэлэх гол үзүүлэлт нь хууль хэрэгжиж энэхүү эмчилгээний үр дүнд олон зуун хүний амь насыг аварсан бодит тоон үзүүлэлт, амьдралын чанар нь дээшилсэн иргэд байх болно.

Гурав. Шалгуур үзүүлэлт

3.1. Зорилгод хүрэх байдал:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн зорилго түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл энэхүү хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах зохицуулах үндсэн зорилготой байна. Хуулийн бүтэц нь нийт 5 бүлэг, 27 зүйл, 195 заалттай бөгөөд зохицуулах, хамрагдах хүрээг нарийвчлан тусгаж тэдгээрийн чиг эрх үүрэг, хариуцлагыг тус бүрт нь зааж өгсөн байна. Мөн хуулийн хүрээнд хийгдэх эмчилгээ, тусламж үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг нээсэн бөгөөд

эдгээрийг зохицуулах эрх зүйн баримт бичиг удирдамж, журам боловсруулах заалтыг тусгасан байна. Эмчилгээ, тусламж үйлчилгээний үр дүн, мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэх, бодит мэдээллээр мэргэжилтэн болон шийдвэр гаргачдыг хангаж байх тогтолцоог тусгасан байна.

3.2 Практикт хэрэгжих боломж:

Хуульд заасан зохицуулалтуудыг "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд харэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэх субьектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдлийг бууруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг УНТЭ, ХСҮТ, УГТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ болон эрхтэн, эд шилжүүлэн суулгах , нөхөн үржихүйн чиглэлээр үр шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ эрхэлж буй эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд болон тархины үхэл тодорхойлох багийн эмч нар, донор эмнэлгийн эрчимт эмчилгээ, харвалтын тасгийн эмч сувилагч нар, гадаад улс оронд мөн эх орондоо эрхтэн шилжүүлэн суулгуулсан иргэдийн төлөөлөлтэй уулзан санал хүсэлтийг авсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ЭМЯ –ны дэргэд байгуулсан бөгөөд энэхүү ажлын хэсгийг дотор нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний ажлын дэд хэсгүүд болгон мэргэжил бүрээр Түүнчлэн хамтран ажилладаг гадаадын болон ОУ-ын байгууллагуудын эксперт, зөвлөх эмч, профессор, мэргэжилтнүүдийн зөвлөмжийг тусгасан болно.

Мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуульд оруулах нэмэлт саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

Одоогийн байдлаар манай улсад Эрхтэн, эд шилжүүлэн суулгах эрх бүхий УНТЭ, ХСҮТ, ГССҮТ, ЭХЭМҮТ эмнэлгүүдэд бөөр, элэг, ясны чөмөгнөөс үүдэл эс, шөрмөс, ясны ялтас шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийж гүйцэтгэн олон арван иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалж амьдралын чанарыг эрс дээшлүүлэн ажиллаж Монгол хүн эх орондоо дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ үйлчилгээг хүртэх боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Түүнчлэн нойр булчирхай, зүрх шилжүүлэн суулгах мэс засал, нүдний эвэрлэг болон мезенхемийн гаралтай үүдэл эсийг эд эсийг нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээнд хэрэглэх арга технологуудыг практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр баг хамт олон байгуулагдан эмчилгээний заавар, удирдамж журмуудыг боловсруулан зохих байгууллагуудаар хэлэлцүүлэн батлуулж байна.

Монгол Улсын анагаах ухааны салбарт эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж байна. УНТЭ-т 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийснээс хойш өнөөдрийг хүртэл Монгол Улсын анагаах ухааны салбарт эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж байна. УНТЭ-т 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийснээс хойш 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 250 иргэнд энэхүү эмчилгээг хийж

гүйцэтгэсэн ба үүнээс 331 иргэнд амьд донороос, 41 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан, эмчилгээний үр дүн 93% байна.

УНТЭ-т Элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг 234 хүнд (222 иргэнд амьд донороос, 12 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан, эмчилгээний үр дүн 94%), ясны чөмөг шилжүүлэн суулгах эмчилгээг 32 хүнд амжилттай хийсэн бөгөөд үр дүн 87,6% байна.

Мөн амьгүй донороос авсан шөрмөс болон ясны ялтасыг ашиглан шөрмөс нөхөх, ясны дефектийг засах, арьс нөхөх мэс заслыг УНТЭ, ГССҮТ, ТТАХН эмнэлгүүдэд амжилттай хийгдэж байна. Цаашид эд шилжүүлэн суулгах эмчилгээг улам өргөжүүлэн зүрхний хавхлаг, судас шилжүүлэн суулгах эмчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

2018 оноос ХСҮТ-д элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг хийж эхэлсэн бөгөөд 118 хүнд энэ эмчилгээг хийснээс 107 иргэнд амьд донороос, 11 иргэнд амьгүй донороос эмчилгээ хийж үр дүн 92% байна. Мөн 2022 онд Зүрх шилжүүлэн суулах , нойр булчирхай шилжүүлэн суулгах үндэсний багууд байгуулагдан бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Эрхтэн шилжүүлэн суулгах өндөр өртөгтэй мэс засал эмчилгээний нэг тохиолдлын зардал нь ойролцоогоор 30 -130 сая төгрөг болдог ба 2017-2020 онд улсын төсвөөс санхүүжилт суулгаж өгсөн нь Эрхтэн,эд эс шилжүүлэн суулгах эмчилгээний цар хүрээ нэмэгдэхэд мэдэгдэхүйц ахиц гаргахад нөлөөлж байна.

Донорын тухай хууль амьдрал, практик үйл ажиллагаанд бодитоор хэрэгжиж үр дүн сайтай байгаа боловч энэ хугацаанд амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг нэмэгдүүлэх, тархины үхэлтэй буюу амьгүй донорын үйл ажиллагааны эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай байгаагийн зэрэгцээ амьд болон амьгүй донорын хүрэлцээг нэмэгдүүлэх, амьд донор түүний реципиентийн нийгмийн халамжид анхаарал хандуулах мөн амьгүй донороос эрхтэн эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний үеийн зардал санхүүжилтийг гүйцэтгэлээр нь шийддэг болох энэ үйл ажиллагаанд оролцож буй донор эмнэлэг, эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлс, илүү цаг, урамшуулалын асуудлуудыг цогцоор шийдэх, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим технологийг бий болгох тогтмол үйл ажиллагааг хангах журам гаргах нөхцлийг бүрдүүлэх зэрэг шаардлага байгаа болно. Түүнчлэн амьгүй донороос авч болох эрхтэн, эд, эсийн тоо олшрох түүнийг хэрэглэж нэгэн зэрэг олон хүн ам насыг аврах, амьдралын чанарыг дээшлүүлэх, ажил төрөлдөө эргэн орох, нийгэмдээ идэвхтэй байр суурийг эзлэх боломжийг бүрдүүлэх нь боломжийг нээж өгөх харилцааг зохицуулах нь энэ хуулийн гол зорилго байх юм.

Өнөөгийн байдлаар УНТЭ, ХСҮТ, ГССҮТ, ЭХЭМҮТ нь хамтран болон бие даасан байдлаар бөөр болон элэг шилжүүлэн суулгах эмчилгээг хийж гүйцэтгэж

байгаа бөгөөд эдгээр эмнэлгүүдийн тухайн чиглэлд ажиллаж байгаа эмч, мэргэжилтэн, сувилагч нар өөрсдийн үндсэн ажлын зэрэгцээгээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах маш нарийн төвөгтэй, хэцүү эмчилгээ үйлчилгээг анх хийж эхэлсэн цагаасаа хавсран гүйцэтгэж цаг наргүй, идэвхи зүтгэл гарган ажиллаж ирсэн. Энэ байдал нь эмч, мэргэжилтэн, сувилагч, үйлчлэгч нараас гадна тухайн эмнэлгийн зохион байгуулалт, санхүү, удирдлага, менежментед хүртэл хүндрэл учруулдаг. Гэсэн хэдийч эдгээр эмнэлгүүдийн удирдлагын баг, эрхтэн, эд шилжүүлэн суулгах багууд, эрчимт эмчилгээний тасаг маш их ачааллыг үүрэн өдий хэмжээнд хүрч олон зуун иргэдийнхээ амь, нас эрүүл мэндийг сахин хамгаалссар байна. Цаашлаад УГТЭ болон УНТЭ-ийн хамтарсан Зүрх шилжүүлэн суулгах үндэсний баг, нойр булчирхай шилжүүлэн суулгах багууд энэхүү үйл ажиллагаанд хамтран оролцох цаг мөч ойртсоор байна. Эдгээр нь уг үйл ажиллагааг улам нарийн зохион байгуулалт, эдийн засаг санхүүгийн чадамж, тоног төхөөрөмж багаж хэрэгслэлийн хангамж, хүний нөөцийн бэлэн байдлыг бодлогоор зохицуулах шаардлагатай байгааг илтгэнэ.

Манай улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг дэлхийн 90 гаруй улс оронтой мөр зэрэгцэн анагаах ухааны үсрэнгүй хөгжлийн үе шатыг түчээлэн хөгжүүлж яваа хөгжиж буй орон билээ. Бид бусад улс орнуудын нэгэн адил эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг амьд болон амьгүй донороос эрхтэн, эд, эс аван эмчилгээ үйлчилгээгээ гүйцэтгэж байна. НҮБ болон ДЭМБ-аас өөрийн гишүүн орнуудад тэр дундаа ямар нэг хэмжээгээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийж гүйцэтгэж буй улс орнуудад өгдөг заавар, зөвлөмж нь энэхүү эмчилгээг аль болох амьгүй донороос авсан эрхтэн, эд ,эсийг ашиглаж байх ёстой гэж зөвлөдөг. Манай улс энэхүү зөвлөмж, зааврийг мөрдлөгө болгон ажиллаж Амьгүй буюу Тархины үхэлд хүрсэн иргэдийнхээ эрхтэн, эд, эсийг эмгэг өвчтэй, өвчнийхөө төгсгөлийн үед орсон иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг аврах боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Энэ үйл ажиллагаанд манай Донор эмнэлэгүүд УГТЭ, ГССҮТ, УНТЭ, УХТЭ маш их идэвхи чармайлттай ажиллаж ирсэн. Цаашид бид аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, дүүргийн эмнэлгүүд болон бусад томоохон улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийг Донор эмнэлэг болгох буюу тухайн эмнэлэгт Тархины үхэл тодорхойлох багийг байгуулан улс орон даяараа сүлжээ үүсгэн ажиллах бэлтгэл ажлуудаа хангаж байна. Үүний тод жишээ Өвөрхангай аймгийн БОЭТ, Дархан хотын нэгдсэн эмнэлэгт ТҮТБ байгуулагдсан бөгөөд цаашлаад Дорнод, Өмнөговь, Ховд, Орхон аймгууд УБ хотын СХД, СБД, БЗД -ийн нэгдсэн эмнэлгүүдийг Донор эмнэлэг болгох үйл явц эхэлсэн билээ. Энэхүү үйл ажиллагааг ЭМЯ, ЭМХТ болон УБ хотын ЭМГ, аймгуудын эмнэлгүүдийн удирдлага дэмжин тусалж хамтран ажиллаж байна. 2023 оны байдлаар нийт 16 эрүүл мэндийн байгууллагад Тархины үхэл тодорхойлох баг байгуулагдан ажиллаж байна. Улсын хэмжээнд Амьгүй донорыг илрүүлэх, гэр бүлээс зөвшөөрөл авах, амьгүй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, тусламж үйлчилгээний нэгдсэн сүлжээ, тогтолцоо үүсэх үндэс суурь бүрэлдэж байна.

Энэхүү өргөн цар хүрээг хамарсан, нарийн төвөгтэй ажлыг зохицуулан зохион байгуулах алба түүний статус, хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хангалт, цалин хөлсний асуудлыг энэхүү хуулийн төсөлд тусган оруулж байна.

МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулна гэж заасан байгаа бөгөөд энэхүү төв байгуулагдснаар хуулийн төсөлд тусгагдаж орсон маш олон асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Иймд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль батлагдснаар энэ салбарын хөгжлийн цоо шинэ үе шат эхлэх бөгөөд илүү чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй болж үйл ажиллагаа илүү эрчимжиж, хэрэгжилт сайжиран олон элэг нэгт Монгол ахан дүүсээ үхлийн аюулт өвчнөөс амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалж сэтгэл санаа, санхүүгийн нүсэр их дарамтаас гаргах болно.

3.3 Ойлгомжтой байдал:

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль нь бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Мөн хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх шаардлага, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Хуулийн нэмэлт өөрчлөлтөд ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн нэр томьёо, хэллэгийг хуульд тусгасан байх бөгөөд хуулийн бичвэрийн томьёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах талаар тусгайлан ирүүлсэн санал байхгүй байна.

3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн саналыг ЭМЯ-ны хэмжээнд энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг эмч, мэргэжилтэн, эрдэмтэн багш, профессоруудаас бүрдсэн томоохон ажлын хэсэг байгуулагдан 4 дэд хэсэгт орж чиглэл тус бүрээр хуулийн төслийг боловсруулан ажилласан болно. УНТЭ, ХСҮТ, УГТЭ, УХТЭ, ГССҮТ, ТТАХНЭ, ЭХЭМҮТ, Үр шилжүүлэн суулгадаг эмнэлгүүдийн удирдлага болон эрхтэн,эд, эс шилжүүлэн суулгах болон тархины үхэл тодорхойлох багийн эмч нар, донор эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн эмч сувилагч нар, гадаад улс оронд болон эх орондоо эрхтэн шилжүүлэн суулгуулсан иргэдийн төлөөлөлтэй уулзаж, санал , хүсэлтийг авсан. Түүнчлэн хамтран ажилладаг гадаадын болон ОУ-ын байгууллагуудын эксперт, зөвлөх эмч, профессор, мэргэжилтнүүдийн зөвлөмжийг тусгасан болно.

“Донорын тухай хууль” 2018 онд шинэчлэн батлагдаж түүнийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх журмуудын хэрэгжилтийг хангах явцад гарч байсан

санал, дүгнэлт, бодит амьдрал, үйл ажиллагааны явцад тохиолдсон асуудал, хүндрэлтэй байдлуудыг шийдэх болон шинэ тутам үүсэн хөгжиж байгаа эд болон эс шилжүүлэн суулгах эмчилгээний талаар хуулийн төсөлд цоо шинээр боловсруулан мэргэжилтнүүдийн санаа оноо, бодол оюун ухааныг тусгасан. Донорын тухай хууль маань тухайн үеийн хэрэгцээ шаардлагыг зохицуулж байсан боловч цагийн аясаар Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай бие даасан хууль байх хэрэгтэй болсон нь амьдрал практик үйл ажиллагааны явц харуулж байна. Иймд энэхүү хуулийн төсөл нь мэргэжлийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, практик үйл ажиллагаанд илүү нийцсэн баримт бичиг болно. Дэлхийн 90 гаруй улс оронд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд эдгээр орон бүрт уг үйл ажиллагааг зохицуулах биеэ даасан эрх зүйн акт буюу хуультай байна.

3.5 Зардал –Зардлын тооцоог Хавсралт 4 дагуу хийсэн болно.

3.6 Харилцан уялдааг хангасан байдал:

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль нь харилцан уялдаа холбоог хангасан байдлыг энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хуультай уялдсан байна. Харин хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасны дагуу Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Донорын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Харьяатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүснэ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7. бусад хуулийн заалтыг	**Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт**

	давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэг болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	**хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна. Энэ хэсэгт хуулийн төслийг сайтар**
4	29.1.10. шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 19 хуулийн төсөл, 1 УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан байна. Сангийн яамны саналын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хасах нь зүйтэй байна.

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд нэр томьёог Тайлбар хэлбэрээр туссан байна. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлэг болон төсөлд ирүүлсэн саналаас үзэхэд "мэргэжлийн байгууллага", " " зэрэг нэр томьёог найруулга, бичвэрийн томьёоллын хувьд ойлгомжтой болгох шаардлагатай
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.

5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Тийм	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд тусгасан агуулга нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгтэй нийцэж байгаа эсэхийн нягтлах,
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	үгүй	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах явцад шаардлагатай нэмэлт зохицуулалт гарч болох талтай.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Тийм	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд "шүүх шинжилгээний хийх эрх" олгох, сунгахад төлөх тэмдэгтийн хураамж болон зарим төрлийн шүүх эмнэлгийн шинжилгээнд тэмдэгтийн хураамж авах зохицуулалтыг тусгасан.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.

13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн тусгагдаагүй болно.
15	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний Ёс зүйн удирдамж, ДЭМБ-ын 11 зарчим зэргийг баримталж ажиллах ёстойг зааж тусгасан.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулсан байх тул нэмэлтээр оруулах шаардлагагүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанд донор эмнэлгүүд болон эрхтэн,эд эс шилжүүлэн суулгах төв, багуудаас ирүүлсэн саналуудыг үндэслэн хийлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль нь дэвшүүлсэн зорилгоо хангах эсэх, практикт хэрхэн хэрэгжих эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлт**ийг хийж, **Зөвлөмж** боловсруулллаа.

ДҮГНЭЛТ

- **Зорилгод хүрэх байдал**: Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Зохицуулалтыг илүү нарийвчлах,

хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Монгол Улсын анагаах ухааны салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээ эрчимтэй хөгжиж байна. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль амьдрал, практик үйл ажиллагаанд бодитоор хэрэгжиж үр дүн сайтай байх нь энэ хугацаанд амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг нэмэгдүүлэх, тархины үхэлтэй буюу амьгүй донорын үйл ажиллагааны эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай байгаагийн зэрэгцээ , зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох ,эрхтэн эд,эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны статус, үйл ажиллагааны чиг үүрэг, эрхийг илүү тодорхой болгох, донорын үйл хэргийг олон түмэнд илүү ухамсарлуулан ойлгуулах, амьгүй донорыг илрүүлэх бодит донор болгох үйл ажиллагааны нэгдсэн сүлжээ бий болгох, үндэсний хэмжээний хүлээх жагсаалт бий болгож эд, эрхтэн хуваарилах асуудлыг олон улсын жишигийн адил илүү шудрага ил тод болгох, эмчилгээний үр дүнг тооцох хянах, дата мэдээллийн нэгдсэн бүртгэл мэдээний сан бий болгох явдал юм. Мөн амьд донор түүний реципиентийн болон эмч, мэргэжилтний нийгмийн халамжид анхаарал хандуулах шаардлагай байна.

- **Ойлгомжтой байдал:** Донорын тухай хууль батлагдаад 5 жил 9 сарын хугацаа өнгөрч байна. Донорын тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 26, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдаж байсан бөгөөд Эрхтэн , эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг Донорын тухай хуульд байсан эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах хэсгийг авч өнөөгийн нөхцөл шаардлагад нийцүүлэн өөрчилсөн бөгөөд харин цоо шинээр орж ирж буй эс, эд, үр шилжүүлэн суулгах талын зохицуулалтуудыг ойлгомжтой байдлаар боловсруулан оруулсан.

- **Хүлээн зөвшөөрөгдөх байдал:** "Донорын тухай хууль" 2018 онд шинэчлэн батлагдаж түүнийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх журмуудын хэрэгжилтийг хангах явцад гарч байсан санал, дүгнэлт, бодит амьдрал, үйл ажиллагааны явцад тохиолдсон асуудал, хүндрэлтэй байдлуудыг шийдэх зорилгоор энэхүү нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан одоо 2022 оны УИХ-ын Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэгдэн батлагдсан бөгөөд энэхүү хуулиас Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг биеэ даасан хууль болгон боловсруулсан болно. Энэхүү хуулийн төсөл нь ЭМЯ-аас томилон байгуулсан ажлын хэсгээс мэргэжил тус бүрийн ажлын дэд хэсгээр хэлэлцэгдэн боловсруулагдаж зохих мэргэжлийн зөвлөл, хуулийн зөвөлгөө, олон нийтийн санал бодлыг тусгасан болно. Иймд хуулийн төсөл нь нь мэргэжлийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, практик үйл ажиллагаанд илүү нийцсэн баримт бичиг болно.

• **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн зүйл, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн үзэл баримтлалаас гадна эрх бүхий байгууллагуудаас энэхүү хуулийн хүрээнд зохицуулах харилцаатай холбогдуулан батлан гаргасан журам, заавар, стандарт, стандарт тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг олон нэмэлт материалыг ашигласан болно. Харин хуулийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Үүнд:

1. Хүүхдэд эс ,эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг Монгол улсад үнэ төлбөргүй болгох; **(Эрүүл Мэндийн Даатгалын тухай хуулийн 6.1.5-д заасны дагуу)**
2. Тархины Үхэлтэй Донор болсон гэр бүлд оршуулгын зардалд нэмж Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэгийг бэлэн бус байдлаар оршуулгын дэмжлэг болгон өгдөг болгох. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар бүлгийн 20 дугаар зүйлд нэмэлт оруулах замаар;
3. Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй гэр бүл болж 2 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан тохиолдолд бие биедээ донор болох боломжтой болох талаар шинээр тусгаж оруулах;
4. ЭШС эмчилгээнд орох гэж буй эмчлүүлэгчийн амьд донор болох боломжийг өргөжүүлэх талаар нэмэлт оруулах: Реципиентийн ураг төрөл талаас донор болж болох талтай байгаа тул үүнд зохицуулалт хийх; / 1.Хүргэн бэр
   2. Хүргэн бэрийн хадам аав,ээж,төрсөн ах,эгч дүү нар/
5. Хуулийн 12.1 заасан заалтын дагуу Донор болох хүсэлтээ илэрхийлсэн тохиолдолд Донорын картны тэмдэглэгээ хийх журмыг тодорхой зааж өгөх. Цахим карт болгох.
6. Нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулж ажилуулах талаар журам боловсруулж батлах тухай заалтыг нэмэх;
7. Эс, эд шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй нэмэлт заалт оруулах; / үүдэл эс болон эдүүд шилжүүлэн суулгах /
8. Эс, эдийн банк байгуулах тухай заалтыг шинээр нэмэх;
9. Донорын зөвшөөрлийн маягт, карт хэвлүүлэх, зөөвөрлөх, түгээх зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаж өгөх;

10. Дархлаа дарангуйлах эмийн төсвийн санхүүжилтийг улирал тутам зохицуулах арга замыг тусгах;
11. Тархины Үхэлтэй Донор илрүүлэх үйл ажиллагааны үед болон Тархины Үхэлтэй Донороос эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зардлыг Амьд Донороос эрхтэн шилжүүлэн суулгах зардлаас тусад нь Улсын төсөвт суулгуулах талаар нэмэлтээр оруулах /Учир нь Тархины Үхэлтэй Донор байнга яаралтай шөнийн цагаар тохиолддог ба хэзээ Донор бэлэн болох нь тодорхойгүй тул донор эмнэлгийн эмч, сувилагч, багийн гишүүд цаггүй ажилладаг/;
12. Донор эмнэлгээс гарч буй зардал болон донор эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрмжийн санхүүжилтийг зохицуулах арга замыг тусгах;
13. Эрхтэн шилжүүлэн суулгах эрх бүхий эмнэлэг нь Амьд Донороос ЭШС эмчилгээнд орох өвчтөний хоорондын хамаарлын болон бусад холбогдох материалыг ЭЭЭШСҮАЗА-нд 14 хоногийн өмнө өгч шалгуулан зөвшөөрөл авах талаар шинээр тусгаж оруулах;
14. Гадаадад эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх иргэд ЭЭЭШСҮАЗА-нд бүртгүүлсэн байх талаар нэмэлт оруулах;
15. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ нь маш нарийн төвөгтэй, олон үйл ажиллагааны нийлбэр болж улам өргөжин тэлж, хөгжиж байгаа бөгөөд эдгээр харилцааг зохицуулан зохион байгуулах албаны талаар оруулах.

- О -

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төсөлд тандан судалгаа хийв.

"Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулиар зохицуулах харилцаа нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул тандан судлах ажиллагааг аргачлалын 1.2-т заасан үе шатын дагуу гүйцэтгэв.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1.Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал

Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1.1.Эрх зүйн зохицуулалтын талаар

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын гуравдугаар бүлэг (Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам)-ийн 3.1 дэх хэсэг (Оршин тогтнохуйн аюулгүй байдал)-ийг мөрдлөг болгосон. Энэ хэсэгт: "*Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн"* гэж заасан.

"Монгол Улсын хүн амын өсөлтийг дэмжиж, Монгол хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргана" хэмээн заасныг хуулийн төсөл боловсруулахад баримталсан болно.

УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 12 дугаар тогтоолын 1.17-д заасан заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор "Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийг боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Нийгмийн бодлого хэмээх Гуравдугаар бүлгийн 3.1.11-т "Олон улсын жишигт нийцсэн оношилгоо, эмчилгээний төв байгуулж, эрүүл мэндийн салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар гадаадад гарах мөнгөн урсгалыг бууруулах зорилт дэвшүүлж байсан.

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-д зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах гэсэн зорилт дэвшүүлсэн байна. Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна” (2.1.3.1), “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал Алсын хараа 2050”-ын 2.2.13-д “Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулна” гэж тус тус заасан нь энэхүү хуулийн төслийг боловсруулах үндсэн шаардлага болсон бөгөөд эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд урьтал нөхцөл болох эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох явдал юм.

Түүнчлэн Монгол Улсад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг зохицуулах биеэ даасан хууль өнөөг хүртэл байгаагүй болно. Эдгээр бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага гарсан болно.

Монгол Улсын “Донорын тухай” хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2018, 2021 болон 2022 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулиар бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дурааараа цус, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа болно.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг боловсруулах нэг шалтгаан нь анагаах ухааны практикт эрхтэн болон эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ арга технологи нэвтэрч эрчимтэй хөгжиж байгаагаас гадна сүүлийн жилүүдэд хүн ам тогтвортой өсөн нэмэгдэж тэдний дунд эрхтэн шилжүүлэн суулгах болон эд, эс нөхөн сэргээх, үр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх шаардлага улам нэмэгдэж байна.

Сүүлийн 10 гаруй жил өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, хоол боловсруулах зам, элэг, бөөрний эмгэг, хорт хавдар, осол гэмтэл орж байна. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний гол шалтгаан болж байгаагийн зэрэгцээ эдгээр нь мөн эд, эрхтний донор болох боломж болж байна.

Хүснэгт 1



Хүснэгт 2

Хүснэгт 1 болон хүснэгт 2-т ЭМХТ-өөс эрхлэн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт 2020" номонд сүүлийн 10 жил зонхилон тохиолдож буй өвчлөл болон нас баралтын шалтгааны статистик тоо баримтыг харуулж байна.

Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй байгаа эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд орох шаардлагатай иргэдийн Хүлээх жагсаалт (Waiting List) жил бүр хүний тоо нэмэгдэж байгаа бөгөөд донорын эрхтэн хүлээх хугацаандаа эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд орж амжихгүй нас барах тохиолдол цөөнгүй байна.

Хүснэгт 3



Хүснэгт 4



Хүснэгт 3 болон хүснэгт 4-т ЭМХТ-ийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас эрхтэн, эд шилжүүлэн суулгах багуудтай хамтран гаргасан Хүлээх жагсаалтын тоон мэдээлэл байна.

2018 онд шинэчлэгдэн батлагдсан "Донорын тухай" хууль болон тухайн жилдээ Эрүүл мэндийн сайдын тушаалаар 5 журам батлагдсан. Мөн 2019 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар А/164 дүгээр журам батлагдсан бөгөөд энэхүү журам нь 2022 онд дахин шинэчлэгдэж А/198 дугаар тушаал болон өөрчлөгдөж баталагдсан. Эдгээр журмуудын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны явцад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа байнга өсөн нэмэгдэж түүнийг дагаж гарах үр дагавар, шинэ тутам үүсэж буй харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байгаа нь энэхүү биеэ даасан хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Монгол улсын анагаах ухааны салбарт эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж байна. УНТЭ-т 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг амжилттай хийснээс хойш 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 331 иргэнд энэхүү эмчилгээг хийж

гүйцэтгэсэн ба үүнээс 290 иргэнд амьд донороос, 41 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан, эмчилгээний нэг жил амьдрах үр дүн 93% байна. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг 234 хүнд (222 иргэнд амьд донороос, 12 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан, эмчилгээний нэг жил амьдрах үр дүн 94%), ясны чөмөг шилжүүлэн суулгах эмчилгээг 34 хүнд амжилттай хийсэн бөгөөд нэг жил амьдрах үр дүн нь 100% байна.

ХСҮТ-д 2018 оноос элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг хийж эхэлсэн бөгөөд 118 иргэнд энэ эмчилгээг хийснээс 41 иргэнд амьд донороос 10 иргэнд амьгүй донороос эмчилгээ хийж үр дүн 92% байна.

Эрхтэн шилжүүлэн суулгах өндөр өртөгтэй мэс засал эмчилгээний нэг тохиолдлын зардал нь ойролцоогоор 16-120 сая төгрөг болдог ба 2017-2020 онд жил бүр улсын төсвөөс санхүүжилт өгсөн ба нийт 4 жилийн хугацаанд 9,1 тэрбум төгрөг суулгаж өгсөн нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний цар хүрээ мэдэгдэхүйц нэмэгдэн эмчилгээ үйлчилгээнд ахиц гаргахад нөлөөлсөн.

Мөн энэ хугацаанд эмчилгээний шинэ төрлүүд эрчимтэй хөгжиж байна. Эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд хурдацтай хөгжиж иргэдийн амьдралын чанарыг сайжруулж байна. Үүнд:

Эд шилжүүлэн суулгах эмчилгээ илүү хурдацтай хөгжиж, эмчилгээний хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Одоогоор осол, гэмтэл, түлэнхийн шалтгаантай 24 иргэнд нүдний эвэрлэг, 1735 иргэнд арьс, 150 иргэнд шөрмөс, холбогч эд, ясны ялтас зэргийг амжилттай суулгаж амьдралын чанарыг дээшлүүлэн эрүүл мэндийг сахин хамгаалсан байна.

Нүдний эвэрлэгийн өвчлөлийн улмаас хараагүй болон сул хараатай болсон эмчлүүлэгч нарын хараг сайжруулах зорилгоор 1956 оноос хойш Монгол улсын нүд судлалын салбарт нүдний донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслын аргыг нэвтрүүлсэн. Нүдний донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслыг анх 1956 онд анх амжилттай хийснээс хойш, 1989-2000 онуудад 50 орчим, 2004 – 2019 онд 93 иргэнд нүдний донор эвэрлэг шилжүүлэн суулгах эмчилгээг тус тус амжилттай хийсэн. 2020 онд Ковид 19-ийн улмаас энэ үйл ажиллагаа зогссон байна. 2021 оны сүүлээр тээвэр ложистик сэргэж, 2021 оны 12 сард 6 иргэнд, 2022 онд 4 иргэнд донор эвэрлэг шилжүүлэн суулгах эмчилгээг тус тус хийгээд байна. Дээрх хугацаанд тухайн мэс заслын эмчилгээнд шаардлагатай донор эвэрлэгийг гадаадын тусламжаар болон АНУ-аас импортоор авч мэс заслыг хийж байна.

Түүнчлэн төмсөг, өндгөвчний төрөлхийн болон олдмол дутмагшил, удамшлын зарим хамшинж, төрөлхийн гаж хөгжил, хавдрын эмчилгээ зэргийн үед үйлчлүүлэгчийг үргүйдлийн эмчилгээнд хамруулахад зөвхөн донор бэлгийн эс хэрэглэх =шаардлагатай байдаг. Эмэгтэйчүүдийн мэс заслын улмаас эсхүл төрөлхийн гаж хөгжилтэй эмэгтэйчүүд зөвхөн тээгч эхийн тусламжтай хүүхэдтэй болох боломжтой байдаг зэргээс үүдэн бэлгийн эсийн донор, тээгч эхтэй холбоотой тусламж, үйлчилгээний харилцааг зохицуулах шаардлага бий болсон. Үр шилжүүлэн суулгах эмчилгээ манай улсад амжилттай хөгжиж байгаа бөгөөд улсын болон хувийн хэвшлийн нийт 5 эмнэлэгт энэ төрлийн эмчилгээ үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Энэ эмчилгээний үр дүнд одоогоор 974 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг амжилттай хийснээр 442 гаруй хүүхэд төрж эсэн

мэнд бойжиж байгаа бөгөөд олон залуу гэр бүлүүдэд аз жаргал бэлэглэсэн байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орны эмч, эрдэмтэд одоогоор эмчлэгдэхгүй байгаа болон эмчлэхэд төвөгтэй халдварт болон халдварт бус олон төрлийн өвчин эмгэгийг эмчлэх шинэ арга замуудыг хайн эрэлхийлж, судалж, туршиж гайхамшигтай итгэл найдвар төрүүлсэн үр дүнгүүд гарсаар байна. Энэ нь Stem Cell буюу үүдэл эсийг анагаах ухааны салбарт өргөн хэрэглэж эхлэх эрин үе эхэлж байгаа явдал юм. Сүүлийн жилүүдэд үүдэл эсийг хүнээс өөрөөс нь ялган гарган авч өсгөх үржүүлэх цаашлаад энэхүү үүдэл эсийг нь индуктор буюу чиглүүлэгч эм, тариатай хослуулан тухайн хүнд нь буцаан хийх замаар эмчлэгдэхгүй байгаа өвчин (Чихрийн шижин, чихрийн шижингийн шарх, шархлаа, үе мөчний эмгэг гэх мэт) эмгэг, гэмтэл, шарх шархлааг эмчлэх, эс, эд, эрхтнийг нөхөн сэргээх эмчилгээнд өргөн ашиглаж эхэлсэн.

Түүнчлэн цусны хавдрын тохиолдол жилээс жилд нэмэгдэж байгаа нь донороос өвчтөнд цусны үүдэл эс шилжүүлэн суулгах хэрэгцээг бий болгож, донороос өвчтөнд цусны үүдэл эс шилжүүлэн суулгах, хүйн цусны донорын банк болон цусны үүдэл эсийн банк байгуулах шаардлагатай байгаагаас гадна насанд хүрсэн хүнээс өөрөөс нь (өөхөн эдээс) ялган гаргаж авсан үүдэл эсийг эс, эд нөхөн сэргээх эмчилгээнд ашигладаг дэлхийн анагаах ухааны шинэ салбарыг хөгжүүлэх шаардлага гарч байна. Ясны чөмөг болон захын цуснаас үүдэл эс ялгах нарийн төвөгтэй эмчилгээний арга технологид шаардагдах эм тариа, урвалж бодисыг цаг алдалгүй түргэн шуурхай хангах, аллотрансплантацийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Донорын тухай хууль 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж хуульд заасны дагуу Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байгуулсан явдал Тархины үхэлтэй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд эрчимтэй ахиц гарсан. Тус алба байгуулагдсанаас хойш эрхтэн шилжүүлэн суулгах баг, донор эмнэлэгтэй хамтарч ажиллах гурвалсан гэрээг УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, УХТЭ, Өвөрхангай БОЭТ, Дархан Нэгдсэн эмнэлэг зэрэг нийт 6 эмнэлэгтэй байгуулан ажилласнаар эрүүл мэндийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирч, тархины үхэлтэй донорын илрүүлэг нэмэгдсэн. Зохицуулах алба байгуулагдсанаас хойш нийт 26 бодит донороос 58 (35 хүнд бөөр, 23 хүнд элэг) хүнд амьдрал бэлэглэж, 150 гаруй хүнд шөрмөс, судас, яс шилжүүлэн суулгах эмчилгээ хийн амьдралын чанарыг дээшлүүлсэн болно. Мөн нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын бэлтгэл ажлын хүрээнд 2 удаа тархины үхэлтэй донороос эрхтэн авах ажилбарыг хийсэн. Зүрх шилжүүлэн суулгах үндэсний багийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн болно. Зүрх шилжүүлэн суулгах багийн хамт олон үйл ажиллагааныхаа удирдамж заавар болон ажиллах журмыг боловсруулан ЭМЯ – нд өргөн барихад бэлэн болж байна.

Манай улсын хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр эмчилгээ үйлчилгээний цар хүрээ, хэрэгцээ шаардлага улам ихсэж тэр дундаа шинэ тутам хөгжиж байгаа эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ улам өргөжин тэлэн хөгжиж өнөө үед энэхүү нарийн мэргэжлийн эмчилгээ, тусламж үйлчилгээг зохицуулах эрх зүйн баримт бичиг, бие даасан хууль, дүрэмтэй байх шаардлага нь цаг үе, амьдралаас урган гарч ирсэн байна.

1.1.2. Практик хэрэгжилтийн байдал

Донорын тухай хууль амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний цар хүрээг өргөтгөх, тархины үхэлтэй буюу амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээтэй холбогдох эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох шаардлагатай байна. Мөн амьд болон амьгүй донорын хүрэлцээг нэмэгдүүлэх, амьд донор түүний реципиентийн нийгмийн халамжид анхаарал хандуулах мөн амьгүй донороос эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний үеийн удирдлага зохион байгуулалт, бүтэц, зардал санхүүжилтийг шийдэх нь чухал байна. Мөн уг үйл ажиллагаанд оролцож буй эмнэлэг, эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлс, илүү цаг, урамшууллын асуудлууд, нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим технологийг бий болгох зэрэг олон асуудлуудыг цогцоор нь эрхтэн, эд, эс шилжүүлэнсуулгахэмчилгээнийталаарх биеэ даасан шинэ хууль боловсруулан баталгаажуулж уг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь энэхүү нотолгоонд суурилсан шинэ төрлийн эмчилгээ, тусламж үйлчилгээг улам илүү хүртээмжтэй, дэлхийн жишигт нийцсэн чанартай, соёлтой, үр дүнтэй, элдэв чирэгдэл хүндрэл багатайгаар ард олон түмэндээ хүргэх нөхцөл бүрдэнэ.

2010-2018 оны байдлаар 450 гаруй иргэн элэг болон бөөр шилжүүлэн суулгах мэс засал, болон бусад эмчилгээ хийлгэхээр гадаад улс руу явсан байх ба эмчилгээний зардалд хамгийн багадаа 80 гаруй тэрбум төгрөг зарцуулсан гэдэг тооцоо байна. Энэ нь эмчлүүлэгч болон тэдний гэр бүлд асар их эд материал, санхүүгийн болон сэтгэл санааны дарамт, чирэгдэл учирч их хэмжээний хөрөнгө гадагшаа урсан гарч байна. Үүнээс зөвхөн элэг шилжүүлэн суулгах эмчилгээ гадаад улсад БНСУ, БНХАУ, БНЭУ-д хийлгэсэн 350 гаруй иргэн УНТЭ-ийн элэг шилжүүлэн суулгах багийн хяналтад байна.

Энэ хугацаанд гадаад улс оронд үр шилжүүлэн суулгах, эс, эд нөхөн сэргээх (шөрмөс,холбогч эд, ясны ялтас, гоо сайхан) мэс заслын болон үүдэл эсийн эмчилгээг хэдэн хүн хэдий хэр зардлаар хийлгэсэн тухай бодит тоо баримт үгүй байна.

Эрхтэн шилжүүлэн суулгах өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний нэг тохиолдлын зардал нь ойролцоогоор 30-350 сая төгрөг болдог. Харин Монгол Улсын Их Хурал, Засгын газраас 2017-2020 онд улсын төсвөөс 9,1 тэрбум төгрөгийг төсөвт суулгаж өгснөөр эмчилгээний цар хүрээ мэдэгдэхүйц нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээнд ахиц гарсан бөгөөд энэ хугацаанд эх орондоо дэлхийн өндөр хөгжилтэй улс оронд хийгддэг эмчилгээ үйлчилгээг хамгийн бага зардлаар, явдал чирэгдэл, хүндрэлгүй авч байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2020 онд шинэчлэгдэн батлагдаж 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд ЭМДҮЗ-ээс 2021 онд гаргасан 03 дугаар тогтоол, 2022 онд баталсан 01 дүгээр тогтоолын дагуу эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж байгаа болно.2021-2022 онуудад хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч энэ жил бүр тодорхой тооны хүнд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийх хязгаартай байна. Түүнчлэн 2022 оны 6 сард ДтХ-д нэмэлт өөрчлөлт орж амьд донорын насыг 21 болгосон бөгөөд амьгүй донор болж бусдын амь нас эрүүл мэндийг аварсан хүний оршуулгын зардалд дэмжлэг үзүүлэх боломжийг ханган ажиллаж байна.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэл болгон донорын үйл ажиллагаанд Эрхтний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг тунхаглал[1] зэргийг удирдамж болгон Донорын тухай хуулийн үзэл баримтлал шинэчлэгдэж, хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд өөрчлөлт орох тул хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.1-д заасны дагуу "Эрхтэн ,эд, эс шилжүүлэн суулгах тухай" хуулийн төслийг боловсруулна.

1.2 Асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгийг тогтоох;

Хуулийн төсөлд дараах бүлгийн эрх ашиг хөндөгдөнө.

№	Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг	Тэдний эрх ашгийн сонирхолд ямар байдлаар нөлөөлж байгаа
1	Иргэд	Төсөлд амьд болон амьгүй донор, реципиент гэсэн субъектийг тодорхойлж өгсөн ба эдгээр нь өөрөө энэ төрлийн эмчилгээ үйлчилгээ авахыг хүссэн бөгөөд бусдын амь нас, эрүүл мэндийг аврахын тулд энэ харилцаанд сайн дураараа оролцогч болох эрх үүргийн харилцаа үүсэж байгаа болно. Амьгүй донорын гэр бүлд донор болох хүсэлтийг албан ёсоор тавьж тухайн гэр бүл хүсэлтийг зөвшөөрөн хүлээн авсан тохиолдолд бусдын амь нас, эрүүл мэндийг аврах үйл хэргийг үргэлжлүүлэгч болно. Ингэснээр өвчин эмгэгийн төгсгөлийн үе шатанд орсон эмчлүүлэгч (иргэн хүн) эрүүл саруул болж амь нас нь аврагдах, цаашлаад нийгэмдээ идэвхтэй байр суурь эзэлж, ажил хөдөлмөр эрхлэн баялаг бүтээгч болох боломж нээгдэнэ.
2	Иргэд	Эд шилжүүлэн суулгах эмчилгээг осол, гэмтэлд орсон болон түлэгдсэний улмаас зөөлөн эд нөхөгдөж сэргэхгүй удах, эмчилгээ авахгүй байдал улам хүндрэх, тахир дутуу болох амь насаа алдах хүртэл хүнд байдалд ордог тул нөхөн сэргээх, зөөлөн эдийг орлуулах эмчилгээний үр дүнд өвчин эдгэрэх, биеийн байдал сайжирч, амьдралын чанар дээшилж нийгэмд идэвхтэй байр суурь эзлэх, хөдөлмөрийн чадвартай болж ажил хөдөлмөр эрхлэн баялаг бүтээгч болно.
3	Иргэд	Тодорхой шалтгаанаар жирэмсэн болох үр тогтоох боломжгүй, жирэмслэх чадваргүй болсон иргэд Үр шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээг хүртсэнээр үр хүүхэдтэй болж гэр бүлийн аз жаргал цогцолж, гэр бүл

[1]Турк,Истанбулхот, 2008 оны 5 дугаарсард батлагдсан.

		тогтвортой болох цаашлаад Монгол улсын хүн ам өсөх үйл явцад сайнаар нөлөөлнө.
4	Иргэд	Хүний үүдэл эсийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зааврын дагуу эмчилгээ үйлчилгээнд ашиглах, эмчилгээний судалгаа хийснээр одоогоор бүрэн эмчлэгдэж чадахгүй байгаа олон өвчин эмгэгийг эмчлэх, илааршуулах боломж бүрдэх бөгөөд иргэдэд эмчилгээний шинэ арга хэлбэрийг сонгох сонголт бий болно.
5	Аж ахуйн нэгж байгууллага	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийж буй эрх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага нь өвчин эмгэгтээ шаналж зовж буй иргэнийхээ эрүүл мэнд, амь насыг аврах үйл хэргийг хэрэгжүүлэхэд таатай нөхцөл боломжийг нээн өгч, энэ эмчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх үр ашгийг сайжруулах нөхцөл бололцоог бүрдүүлснээр энэ этгээдийн эрх ашигт нийцэж, өөрсдийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
6	Аж ахуйн нэгж байгууллага	Энэ төрлийн эмчилгээ үйлчилгээ хийж буй эрүүл мэндийн байгууллага хүний нөөц болон эмчилгээ үйлчилгээний шинэ арга технологи нь хөгжин дэвших бөгөөд шинэ технологийг дагаж шинэ багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдан суурилагдаж, эмчилгээ үйлчилгээний цоо шинэ харьцаа, тогтолцоо бий болж өргөн утгаараа тухайн байгууллага хөгжин дэвжих юм.
7	Төр, төрийн албан хаагч	Хуулийн төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор дагаж гарсан удирдамж, журмаар энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлж буй эмч эмнэлгийн мэргэжилтний эрх, ашиг үүрэг оролцоо, харилцааг зохицуулахаар заасан болно.

Эдгээр эерэг үр дагавар үүсгэх нөлөөллийн улмаас одоо хүчин төгөлдөр үйлчилж буй "Донорын тухай" хуулийн зүйл заалтыг улам төгөлдөржүүлэн эмчилгээний шинэ арга, технологийн харилцааг зохицуулах зохицуулалтуудыг нэмж боловсруулан оруулж эрх зүйн шинэ орчинг бүрдүүлэх юм. Ингэснээр жишигт нийцсэн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ төрөл, арга технологийн харилцаа, уялдаа холбоог зохицуулах боломж бодитоор бүрдэнэ.

1.3 Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох;

Монгол Улсын хүн ам тогтвортой өсөн нэмэгдэж одоо 3.4 сая гаруй болсон бөгөөд хүн амын дунд 45 хүртэлх настай иргэд 2615 270 буюу хүн амын 70 гаруй хувийг эзэлж байна. Хүн ам тогтвортой өсөж, залуучуудын эзлэх хувь өндөр байгаа нь ирээдүйд өвчин эмгэг өсөх хандлагатай байна гэдгийг харуулж байна. Энэ хэрээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээний хэрэгцээ шаардлага нэмэгдэх болно.

1.3.1. Цуллаг эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хэрэгцээ

ДЭМБ болон Дэлхийн Бөөрний эмч нарын нийгэмлэгээс гаргасан дүгнэлтээс үзэхэд 1 сая хүн ам тутамд жил бүр 100 гаруй хүн бөөрний

түүдгэнцэрийн эмгэгтэй болж бөөр орлуулах эмчилгээ цаашлаад бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх шаардлагатай болдог гэж үзжээ.

Манай улсын хувьд сүүлийн 10 гаруй жил өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, хоол боловсруулах зам, элэг, бөөрний эмгэг, хорт хавдар, осол гэмтэл орж байна. Энэ нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний гол шалтгаан болж байгаагийн зэрэгцээ эдгээр нь мөн эд, эрхтний донор болох боломж болж байна. Эдгээр бодит байдлууд энэхүү асуудлыг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг1



Монгол улс Элэгний В вирусийн тархалтаар нийт хүн амынхаа 8 хувиас илүү тархсан улс орнуудын тоонд орсон байна.

Зураг 2

Хамгийн өндөр түвшин Египет (14,9%), Тайвань (4,4%), Пакистан (3,0%), Монгол (12,3%)

CDA Centre for Disease Analysis. http://www.c4da.com/Maps/World%20NP.jpg. Accessed August 20, 2013.

“Center for Disease Analosis”-аас 2012 онд гаргасан судалгаанд С вирусийн тархалт Монгол улсад нийт хүн амын дунд өндөр байна гэж үзжээ.

Зураг3



Эх сурвалж: (DOI:10.1016/S0140-6736(11)60448-0)

“The Lancet”-ийн 2011 онд хийсэн судалгаагаар Монгол улс элэгний хавдрын тохиолдлоор дэлхийн дунджаас даруй 6 дахин их байна гэж үзсэн.

Хүснэгт 5



Хүснэгт6

Хүснэгт 7

Хүснэгт 8

Хүснэгт 9

Хүснэгт 10



Хүснэгт 5-10 нь ЭМХТ-өөс эрхлэн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт 2020-2021" статистик үзүүлэлт

Эдгээр бодит тоо баримт нь манай улсын хэмжээнд эрхтэн тогтолцооны эмгэг ямар өндөр төвшинд байгааг харуулахаас гадна энэ байдлыг өөрчлөхийн тулд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог тогтмол иргэд олон түмний дунд хэвшүүлэн хийдэг болох ингэснээр эрт илрүүлэг хийгдэж өвчин эмгэг илүү хүндрэх, эрүүл мэндэд хохиролтой болох, эмчилгээнд нь илүү их цаг, зардал гаргах цаашлаад амь нас хохирох байдалд хүрэхээс зайлсхийх боломж бүрдэнэ. Харин нэгэнт цаг хугацаа алдаж оношлогдон өвчин эмгэг илүү хүндэрсэн байгаа иргэдэд эмчилгээний хамгийн үр дүнтэй арга нь эд, эрхтэн шилжүүлэн суулгах явдал юм. Энэ нь эрсдэл ихтэй, өртөг өндөртэй арга зам ч эрүүл мэнд, амь насыг аврах цорын ганц арга болж байна

1.3.2 Эд шилжүүлэн суулгах эмчилгээний хэрэгцээ (Арьс, нүдний эвэрлэг, шөрмөс, ясны ялтас)

1.3.2.1. Нүдний эвэрлэг

ДЭМБ-ын судалгаагаар эвэрлэгийн шалтгаант сохрол нь Дэлхий дахинд тохиолдож байгаа нийт сохролын 4 дэх гол шалтгаан болдог. Бүх сохролын 5.1%-ийг эзэлдэг. Дэлхий дахинд 12.7 сая хүн эвэрлэгийн шалтгаантай сохролтой байна.Үүний 98% хувь нь ядуу буурай болон хөгжингүй оронд тохиолдож байна. Жилд дэлхий дахинд 350000 хүүхэд төрөлхийн эвэрлэгийн бүдэгшил болон эвэрлэгийн халдварын шалтгаанаар сохордог. Монгол улсад 1994 оны Ж.Баасанхүү, G.J. Johnson нарын "Монгол дахь 40-с дээш насныхны сохрол сул харааны судалгаагаар" нийт сохролын 7,2 %, сул харааны 19,3 %-г эвэрлэгийн шалтгаант эмгэгүүд эзэлж байна.

2013 оны Д.Уранчимэг нарын 50-с дээш насны "Зайлсхийж болох сохрол, сул харааны тархалт, түүний шалтгаан" судалгаагаар трахомын бус шалтгаант эвэрлэгийн бүдэгшилийн тархалт нь 13,3 % байна.

Дээрх 2 судалгаанаас үзэхэд эвэрлэгийн шалтгаант хараа алдалт нь нүдний глауком, болор цайх эмгэгүүдийн дараа сул харааг үүсгэж байгаа тэргүүлэх 3 шалтгааны нэг болж байгаа нь харагдаж байна. Үүнээс гадна хүүхэд ба насанд хүрэгсдийн төрөлхийн ба олдмол эвэрлэгийн бүдэгшил, нүдний эвэрлэгийн нэвт гэмтэл, гэмтлийн гаралтай эвэрлэгийн сорвижилт, эвэрлэгийн эндотелийн декомпенсац, халдварт үрэвслийн гаралтай эвэрлэгийн цооролт ба сорвижилт, кератоконус нь цөөн бус тохиолдож байна. Эдгээр эмгэгийн үед донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал хийснээр хараа алдах, сул хараа үүсэхээс сэргийлэх бүрэн боломжтой.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд донор эвэрлэг шилжүүлэн суулгах нэн шаардлагатай хүлээх жагсаалтад 100 гаруй тохиолдол бүртгэгдсэн байна. Нүдний донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ нь Эрүүл мэндийн даатгалын санд хамрагддаггүйн улмаас олон иргэн төлбөрийн чадваргүйгээс сохор байдалтай байна. Иймээс эх орондоо нүдний донор эд бэлтгэх, хадгалах, шинжлэх, түгээх үйл ажиллагааг эхлүүлж, цаашлаад нүдний банк байгуулах нь нэн шаардлагатай тулгамдсан асуудал болоод байна. Энэхүү үйл ажиллагааг эхлүүлж нүдний донор эдийн хангамж, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсанаар нүдний тусламж үйлчилгээний хүртээмж сайжран, ард иргэдээ зайлсхийж болох сохролоос сэргийлэх боломжтой болно. Хуулийн төсөл батлагдсанаар нүдний донор эд шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний хүрээ нэмэгдэж, гадаад болон дотооддоо хийгдэж байгаа өндөр өртөгтэй мэс засал үгүй болж, иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үйлчилгээ авах боломжтой болсноор иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх хангагдана.

Нүдний банк нь 1944 онд анх АНУ-д байгуулагдсан. Дэлхий дахинд жил бүр 82 орны 742 нүдний банканд 284 мянган донор эвэрлэг бэлтгэгддэг. Үүнээс чанарын шаардлага хангасан 185 мянган донор эвэрлэгийг 116 оронд шилжүүлэн суулгадаг байна. Дэлхий даяар 12.7 сая хүн эвэрлэг шилжүүлэн суулгах шаардлагатай хүмүүсийн жагсаалтад байдаг ба дээрх жагсаалтын 70 хүний 1 нь мэс засалд хамрагддаг байна.

1.3.2.2. Түлэгдэлт болон арьс нөхөх эмчилгээ

Хүснэгт 11

Насны бүлэг	2016		2017		2018		2019		2020		2021	
	МУ	ГССҮТ	МУ	ГССҮТ	МУ	ГССҮТ	МУ	ГССҮТ	МУ	ГССҮТ	МУ	ГССҮТ
0-4	3148	2417	3165	2310	3451	2606	3614	2775	3628	2599	2981	2155
5-9	502	364	487	353	617	468	614	499	570	413	497	368
10-14	192	138	190	131	249	178	246	190	239	173	191	136
15-19	132	92	173	120	169	127	188	138	187	137	139	107
20-24	228	179	210	171	240	185	319	250	291	219	231	182
25-29	281	220	294	217	344	281	339	240	291	211	265	203
30-34	208	156	244	167	289	215	304	210	343	262	301	216
35-39	195	132	214	145	237	168	243	165	249	180	192	143
40-44	180	119	187	121	217	151	206	145	238	150	217	145
45-49	138	98	140	95	192	129	177	128	196	137	189	123
50-54	112	75	133	89	158	106	146	96	182	130	154	99
55-59	84	59	99	63	125	88	129	95	135	92	110	75
60-64	46	**32**	60	38	68	56	86	**58**	89	58	85	**61**
65-69	31	18	36	28	45	31	38	26	41	26	37	28
70+	43	29	49	32	52	31	55	42	85	57	48	32
Нийт	**5520**	**4128**	**5681**	**4080**	**6453**	**4820**	**6704**	**5057**	**6764**	**4844**	**5637**	**4073**

Жилд дунджаар 6000 орчим хүн түлэгдэлтийн шалтгаант осол гэмтэлд өртсөний улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байна. 2016-2021 онуудад улсын хэмжээнд 36759 тохиолдол бүртгэгдсэний 73.5% /27002/ ГССҮТөвөөс тусламж үйлчилгээ авсан байна. Улсын хэмжээнд түлэгдэж гэмтсэн нийт тохиолдлын 54.4%-ийг, үүнээс ГССҮТөвөөс түлэгдэлтийн улмаас тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын 55.0%-ийг 0-4 насныхан эзэлж байна.

Хүснэгт 12

Түлэгдэлтийн шалтгаант өвчлөл

Сүүлийн 6 жилийн хугацаанд түлэгдэлтийн улмаас ГССҮТ-ийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгаас тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын 20% нь хэвтэн эмчлүүлсэн байна. 2017-2021 онд ГССҮТөвд түлэгдэлтийн шалтгаант гэмтлийн улмаас 2427 мэс засал хийгдсэн ба үүний 74 нь донор арьс нөхөх мэс засал хийлгэсэн байна.

ГССҮТ-ийн сүүлийн 6 жилийн нийт түлэгдэлтийн шалтгаант нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд 42.6%-ийг 0-4 насныхан эзэлж байна. Монгол улсад 2016 оноос ГССҮТ-ийн Түлэнхий нөхөн сэргээх мэс заслын тасагт түлэгдэлтийн шарханд цогцосны аллогрефтийн бэлдэцийг шилжүүлэн суулгах мэс заслыг хийж практикт шинээр нэвтрүүлэн хэрэглэж эхэлсэн. Жилд дунджаар 12000см^2 донор арьс хэрэглэж байгаа бөгөөд жилээс жилд хэрэглээ нэмэгдсээр байна.

Цаашид түлэгдэлтийн шалтгаант өвчлөлийн эмчилгээг илүү үр дүнтэй олон хүний амь нас, эрүүл мэндийг аврахад эдийн банк байгуулах, эмчилгээнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмж багаж хэрэгслээр хангах явдал юм. Энэ бүгдийг эд шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ, харилцааг зохицуулах эрх зүйн орчин шаардлагатай байна.

1.3.2.3.Шөрмөс болон ясны ялтас шилжүүлэн суулгах эмчилгээ

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэгт бид 2019 оноос эхлэн амьгүй (кадавер) донороос яс, шөрмөс авч шаардлагатай үйлчлүүлэгчдэд ашиглан үений үйл ажиллагааг сэргээх мэс заслыг хийж эхэлсэн ба одоогоор давхардсан тоогоор 150 гаруй өвчтөнд олон холбоосын гэмтлийн мэс заслыг амжилттай хийгээд байна.

Шөрмөс гэмтсэн, тасарсан өвчтөнд мэс засал хийж сэргээхдээ өөрийн шөрмөсийг нь эхний сонголтоор ашиглахыг зорих боловч өөрийн шөрмөс нь хэт нарийн байх (дахин тасрах эрсдэлтэй), хавсарсан олон холбоосын гэмтэл (өөрөөс 1-2ш шөрмөс авах боломжтой ба 2-оос дээш холбоосын гэмтэлд өөрийн шөрмөс хүрэлцэхгүй), давтан мэс засал(өмнөх мэс засалд өөрийн шөрмөсийг нь ашигласан), тамирчдад (өөрөөс нь шөрмөс авах нь мөчний чадамжид нөлөөлж, булчингийн хүч буурна) зэрэг шалтгаанаар амьгүй (кадавер)донорын шөрмөс хамгийн оновчтой сонголт болдог.

Гэмтлийн, үрэвслийн, хавдрын улмаас яс гэмтэж өөрөөрөө бороолж нөхөгдөх боломжгүй том хэмжээний дутмагшил үүссэн үед яс нөхөх шаардлагатай болдог. Мөн ясыг өөрөөс авч нөхөж болох боловч дефектийн хэмжээ том үед донор яс зайлшгүй хэрэгцээтэй. Мөчдийг гэмтлийг засахаас гадна мэдрэлийн мэс заслын практикт нурууны нугаламын эргэшгүй өөрчлөлтөд орсон, бусад мэс заслаар эмчлэх боломжгүй эмчлүүлэгчдэд донорын яс ашиглан нугаламын их биеийн нөхөн сэргээх мэс засал хийж бүрэн эмчлэх боломжтой. Шөрмөс сэргээх мэс засал нь жилд 1000 орчим мэс засал ордог ба үүний 100 орчим нь 2 болон түүнээс дээш холбоос гэмтсэн буюу донор шөрмөс шаардлагатай тохиолдлууд байдаг.

Энэ төрлийн мэс заслын хүлээгдэл өнөөдрийн байдлаар нэг сарын хүлээгдэлтэй. Ихэвчлэн гэмтлийн шалтгаантай учир мэс заслыг цаг алдалгүй хийх нь цаашдын хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлдэг.

1.3.3. Нөхөн үржихүйг дэмжих эмчилгээний хэрэгцээ

ДЭМБ-ын тархвар судлалын тодорхойлолтоор "Нөхөн үржихүйн насны хосууд жирэмслэлтээс хамгаалах арга хэрэглэхгүй, тогтмол бэлгийн харьцаанд нэг жил байгаа боловч жирэмслэхгүй бол үргүйдэл гэнэ" хэмээн тодорхойлсон бөгөөд үргүйдэлд хүргэдэг шалтгаан, эрсдэлт хүчин зүйлс нь эмэгтэй, эрэгтэй хүнд ялгаатай, олон төрөл байдаг.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Монгол хүний үргүйдлийн шалтгаан" судалгааны дүнгээс үзэхэд нийт үргүйдэлтэй хосын дунд эмэгтэйчүүдийн 34,8 хувь, эрэгтэйчүүдийн 55,6 хувь нь ямар нэг эмгэг өөрчлөлт илрээгүй буюу шалтгаан тодорхойгүй үргүйдэлтэй, эмэгтэйчүүдийн 56,3 хувь нь анхдагч, 43,7 хувь ньхоёрдогч үргүйдэлтэй байна. Бэлгийн замаар дамжих халдварт өртсөн байдлыг харахад эрэгтэйчүүдийн 44,1 хувь нь, эмэгтэйчүүдийн 43,9 хувь нь уг халдварт өртөж, үүнээс 25,1 хувь нь бага аарцгийн үрэвсэлт өвчнөөр, эмэгтэйчүүдийн 23 хувь, эрэгтэйчүүдийн 53 хувь нь бэлгийн дааврын

үзүүлэлтийн хувьд ямар нэг өөрчлөлт буюу дотоод шүүрлийн тогтолцоонд эмгэгтэй байна.

Манай улсад үр шилжүүлэн суулгах, хүүхэд төлөөлөн төрүүлэх тээгч эхийн харилцаа нэгэнт бий болж, энэ харилцаа ямар ч эрх зүйн зохицуулалтгүй, үр шилжүүлэн суулгах, түүний үр дүнг тооцох аргачлал, тооцож бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй байна. Монголд 2011 оны 11 дүгээр сард анхны үр шилжүүлэн суулгах төв байгуулагдаж байсан бол 2018 оны байдлаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, "Си эйл даблью эйч", "Өөжин мед", "Баянгол" зэрэг эмнэлэгт үр шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээг явуулж байгаа бөгөөд жилд нэг эмнэлэгт жилд 300-500 хос хандаж, оношилгоо, эмчилгээ үйлчилгээ авч байна.

Үргүйдлийн асуудалтай, үр шилжүүлэн суулгах аргаар үр хүүхэдтэй болох хүсэлтэй иргэд БНСУ болон ОХУ-ын эмнэлэгт их ханддаг бөгөөд БНСУ-д 2015 онд зорчихоор эмчилгээний виз авсан 3700, 2016 онд 3100, 2017 онд 3800, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1900 хүн байгаа нь гадагш эмчилгээ, үйлчилгээнд явах хүсэлтэй, түүнээс нөхөн үржихүйд туслах аргаар үр хүүхэдтэй болох хүсэлт их байгааг харуулж байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих зорилгоор үргүйдлийг эмчлэх, орчин үеийн нөхөн үржихүйд туслах аргыг ашиглах, хязгаарлах, хориглох, тухайн харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн үндсийг тодорхойлсон бие даасан хуулийг "Донорын тухай" хуулиас тусад нь батлан гаргах шаардлагатай байна. Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалт буюу үр шилжүүлэн суулгах, тээгч эхээр хүүхдээ тээлгэн төрүүлэх харилцаанд эрх зүйн орчин дутагдалтай байгаагаас нэгэнт үүссэн энэхүү харилцаанаас үүдсэн маргаан нэлээдгүй гарах болоод байна.

Тухайлбал үргүйдэл, түүний тусламж үйлчилгээ, нөхөн үржихүйд туслах арга түүний төрөл, үүнийг ямар шаардлага хангасан эмнэлэг ямар нөхцөлд хэрэглэх, уг ажиллагааны нууцлал, тавигдах шаардлага, эрүүл мэндийн шалтгаанаар үр хүүхэдтэй болох боломжгүй болсон эцэг, эх хүүхдээ тээлгэн төрүүлэх харилцаанд хэрхэн оролцох, тээгч эх гэж хэн байх, тэдгээрт тавигдах шаардлага, талуудын хоорондын гэрээнд ямар асуудал тусгах, тээгч эхээс төрсөн хүүхдийг хэрхэн шилжүүлэн өгөх, хүүхдийг төрсний бүртгэлд бүртгэх зэрэг олон харилцааг хуульчлах шаардлагыг харгалзан энэ хуулийн төслийг боловсруулсан.

1.3.4 Эс шилжүүлэн суулгах эмчилгээ, эсийг нөхөн сэргээх эмчилгээнд ашиглах хэрэгцээ

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хорт хавдар, тэр дундаа цусны хавдрын тохиолдол жил ирэх тусам ихэсч байгаа нь эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн статистик мэдээ ба УНТЭ, ЭХЭМҮТ-ийн сүүлийн 5 жилийн статистик тайлан харуулж байна. Цусны хавдрын өвчлөл ихсэхийн хэрээр энэ өвчний улмаас өвчтөн, ар гэрт учирч байгаа бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн дарамт нэмэгдэхээс гадна эмчилгээний явцад хэрэглэгддэг эсийн бүтээгдэхүүн болон тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулах хууль эрх зүйн баримт зайлшгүй шаардлагатай болж байна.

Монгол улсад 0-19 насны хүүхдүүдийн дунд жилд 130 орчим шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдэж байна. Хүүхдийн хорт хавдрын дийлэнх хувийг

цусны хорт хавдрууд эзэлдэг. Үүний дотор жилд цочмог лимфоид лейкеми хамгийн өндөр буюу 36%, цочмог миелоид лейкеми 17% тохиолдож байгаа ба тэдгээрийн 20-30% нь донороос үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх шаардлагатай байдаг.

Сүүлийн 5 жилд насанд хүрэгсдэд цочмог миелобластын лейкемийн тохиолдлын тоо жилд дунджаар 36.8 (22-55), цочмог лимфобластын лейкеми 20.2 (8-33),цус төлжилгүйдлийн цус багадалт 8 (3-13) бүртгэгдсэн байна. Насны хувьд авч үзэхэд ид хийж бүтээх насандаа буюу 20-40 насанд оношлогдож байна. Цусны үүдэл эсийн 3 эх үүсгэвэр (захын цус, ясны хэм, хүйн цус) байдаг боловч маш нарийн эдийн тохироо шаардлагатай байдгийн улмаас олон улсад 100%-ийн тохироо бүхий донор олох хүндрэлтэй байдаг. Гэр бүлийн гишүүдийн тохирсон донор олдоогүй тохиолдолд төрлийн бус донор болон хүйн цусны үүдэл эсийг ашиглаж болох боловч дараах харилцаанууд зохицуулагдаагүй байна. Үүнд:

1. Эсийн банк байгуулах, бүтэц, үйл ажиллагааны чиглэл тодорхой бус
2. Төрлийн болон төрлийн бус донороос үүдэл эс эмчилгээний зорилгоор авах зохицуулга тодорхой бус
3. Монгол улсад төрөлт нэмэгдэж байгаа статистик үзүүлэлт байдаг, үүдэл эсийг цаашдаа ашигладаггүй биологийн хаягдал болдог хүйн цус ба эдээс нь гарган авах боломжтой боловч хуулийн зохицуулга үгүй
4. Донорын олдоц хомс тул олон улсад эсийн банкнууд хоорондоо мэдээллээ солилцон, тохирох донор олох боломж байдаг боловч дотоод, гадаад эсийн банкуудын хоорондын харилцааг зохицуулсан зохицуулга үгүй.

Алло-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэх өвчтөнүүдийн 5 хүрэхгүй хувь буюу харьцангуй боломжтой хэсэг нь гадаад оронд явж эмчлүүлсэн ба эмчилгээндээ 150 саяас 1 тэрбум төгрөгийг зарцуулсан баримт байна.Орчин цагийн анагаах ухааны хамгийн сүүлийн үеийн ололт амжилтын нэг, хувь хүнд чиглэсэн эмчилгээний шийдэл болох боломжтой аргууд нь ген, эс, эдийн эмчилгээ болж байна. Энэ төрлийн эмчилгээ нь уламжлалт эмчилгээгээр эмчлэх боломжгүй өвчнүүдийг эмчлэх, эмгэг өөрчлөлтөд орж, нөхөн сэргэх, төлжих боломжгүй эс, эд, эрхтнийг нөхөн сэргээж хэвийн үйл ажиллагаанд оруулах боломжийг олгох үүд болж байна.

Сүүлийн жилүүдэд гарч байгаа ололт амжилт, тэр дундаа эмнэлзүйн туршилт судалгаа, эмчилгээний үр дүнгүүд нь эмчлэгдэх боломжгүй өвчнүүдийг эмчилсэн үр дүнгүүд нь энэ шинжлэх ухааны цар хүрээг харуулж байна. Дэлхийд хамгийн анх 1956 онд цусны хавдартай өвчтөнд хэмт яснаас (аллоген) үүдэл эс шилжүүлэн суулгах оролдлого хийн тэрхүү ажил нь 1990 онд Нобелийн шагнал хүртсэн нь өнөөдөр шар толбоны сөнөрөлийн улмаас харааны бэрхшээлтэй болсон өвчтний өөрийнх нь эсээс торлогийн пигментийн хучуур эд болон ялгаран хөгжүүлэх замаар харааны бэрхшээлийг бууруулсан төвшинд хөгжсөн.

Эсийн эмчилгээ сайн хөгжиж байгаа хэдий ч эмчлэх эмчилгээний цар хүрээ, далайц нь удамшлын эмгэг, ховор тохиолдох генийн эмгэгүүд, зарим хавдрын эмчилгээнд төдийлөн үр нөлөө үзүүлэхгүй байсан нь ген засварын технологи хөгжих үндэс болсон. Генийн эмчилгээ нь ДНХ-ийн бай дараалалд генийн бүтээгдэхүүнийг оруулах, таслах, солих чадамжтай нуклеазын тусламжтай

хүссэн генийг засварлах боломж бүхий орчин үеийн судалгааны шинэ салбар бөгөөд ахисан төвшний технологи юм.

2007 онд хамгийн анх бай генийн сонгомолоор засварлах чадамж бүхий нуклеаза "Молекул хайч" гэж нэрлэгдэх энэхүү аргыг нээсэн эрдэмтэд 2020 оны Нобелийн шагналын эзэд болсон. Өнөө үед энэхүү энзимийн эрэлт хэрэгцээ, шинжлэх ухаан болоод практикт олон ач тусыг өгөөд байна. Орчин цагт хамгийн ихээр хэрэглэгдэж буй генийн засварын технологиудад: meganucleases, zinc finger nucleases (ZFNs), transcription activator-like effector-based nucleases (TALEN), Clustered Regularly Interspaced Short Palindromic Repeats (CRISPR/Cas), base editor, prime editor орно.

Ген, эс, эдийн шинжлэх ухааны энэхүү ололт амжилттай эмчилгээний аргуудыг амжилттай хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай технологи нь ген, эс, эдийн банк юм. Ялангуяа, техник технологийн эрин болсон энэ үед нийгэм, эдийн засгийн хөгжлийг даган гарч ирж байгаа олон янзын өвчин эмгэг, архаг өвчнүүд нэмэгдэж байгаа нь олон улсад биобанкны чиглэл хөгжих үндэс болж байна. Мөн биобанктай болсноор шаардлагатай мэдээллийн дата баазтай болохоос гадна оршин буй орчны нөлөөлөл бидний ген, эс, эдэд хэрхэн яаж нөлөөлж байгаа, цаашлаад ген, эс, эдийн эмчилгээнд шинэ арга техник нэвтрүүлэх, бай эмчилгээний загварыг олоход чухал.

Дэлхийн хамгийн анхны биобанк 1862 онд АНУ-д иргэний дайны үед үүсэж байсан бөгөөд дэлхийн улс орнууд 1990 оноос эхтэй өөрсдийн үндэсний биобанктай болж эхэлсэн байна. сүүлийн 30 жилийн хугацаанд дэлхийд нийт үндэсний хэмжээний 120 биобанк бий болсон байгаа бөгөөд 2022 оны байдлаар зах зээл нь 2.69 тэрбум америк долларт хүрсэн байна. Биобанк нь ген, эс, эдээр тогтохгүй цаашлаад микробиома, биомолекул, чөлөөт ДНХ, протеомикс, метаболомиксийн чиглэлээр нарийсан хөгжиж байна. Ген, эс, эдийн био банк нь үндэстэн оршин тогтнохын баталгаа болох үндэсний аюулгүй байдлын нэн чухал хэсэг болох юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Хуулийн бүтэц:

1. Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томьёоны тодорхойлолтыг тусгаж, үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.

2. Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт реципиент болон амьд донорыг сонгох, тэдгээрийн эрх үүрэг, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх болон тавигдах шаардлагын талаар тусгана.

3. Хуулийн гуравдугаар бүлэгт Эрхтэн, эд,эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгаж, эрхтэн, эд, эс авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгана.

4. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар тусгана. Уг үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоог тодорхойлж, Монгол Улсын засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрхийг тусгана. Мөн эрхтэн эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг болон эрүүл мэндийн байгууллагын нийтлэг чиг үүргийг тусгана.

5. Хуулийн тавдугаар бүлэгт бусад зүйл, санхүүгийн тогтолцоо, хяналтын тогтолцооны талаар тусгана.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ нь нарийн төвөгтэй, олон үйл ажиллагааны нийлбэр болж өргөжин тэлж байгаа бөгөөд эдгээрийг зохицуулах нарийн заалт бүхий хууль түүнийг дагаж мөрдөх журам заавар шаардлагатай болж байна.

Энэхүү хууль батлагдаж хэрэгжихтэй холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангаж байх үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, дүн шинжилгээ, судалгаа хийх, олон улсын байгууллагуудтай хамтран энэ салбарын хөгжил, чиг хандлагыг тодорхойлж байх зэрэг олон талт асуудлуудыг бүрэн зохицуулалтыг хангах төрийн байгууллага байгуулах хэрэгцээ шаардлага бий болж байна. Одоогоор энэхүү үйл ажиллагааг 2018 оны Донорын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа билээ.

Тус байгууллага байгуулагдан ажиллах хэрэгцээ шаардлага нь бусад улс оронд, олон улсын байгууллагууд хэрхэн оролцон хамтран ажиллан тухайн улс орны төр засаг эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний цогц үйл ажиллагааг удирдан зохион байгуулан, зохицуулалт хийж, хяналт хийж байгаа талаар товч танилцуулъя.

2.1. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (World Health Organazation)

ДЭМБ нь 1948 онд байгуулагдсан. Одоогоор 194 орон тус байгууллагын гишүүн болсон байна. Швейцарь улсын Женев хотод 1987 оны 5 дугаар сард хуралдсан ДЭМБ-ын 40 дугаар ассамблейн чуулган (WHA40.13)-аар анх удаа хүний эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үндсэн зарчим, стандарт байх талаар шийдвэр гарсан. 1991онд болсон ДЭМБ-ын 44 дүгээр ассамблейн чуулган(WHA 44.25)-аар "WHO Guiding Principles on human cell, tissue and organ transplantation" буюу "ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай үндсэн зарчмууд"-ыг баталсан. Энэ нь нийт 11 зарчмаас бүрдэнэ. Зарчмуудын гол үзэл санаа, утга агуулга нь хүнд эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах эмчилгээг амьд болон амьгүй донороос хийхдээ хууль журмын хүрээнд сайн дурын үндсэн дээр эрх тэгш, ялгаварлан гадуурхалгүй, ёс зүйн хэм хэмжээнд, хүн болон хүний эрхтний наймаа болон ашиг орлого олох сонирхлоос ангид байж аюулгүй, чанар, үр дүнтэй хийгдэж байх ёстой гэж заасан байдаг. Мөн эмчилгээний үр дүн түүний талаарх мэдээлэл бүртгэгдэж, хянагдан ил тод байх ёстой гэсэн байдаг. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж байгаа Дэлхийн 93 улс орон болон Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах

нийгэмлэгийн гишүүн 105 орон түүний нийгэмлэг, холбоод энэхүү зарчмыг баримталж байгаа бөгөөд энэ зарчмуудад тулгуурлан өөрийн орны эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа, харилцааг зохицуулах хууль, дүрэм журмыг гаргасан байдаг.[2]

2.2. Дэлхийн Трансплантацийн Нийгэмлэг (The Transplantation Society-TTS)

Дэлхийн Трансплантацийн Нийгэмлэг нь 1966 онд Канад улсын Монреаль хотод анх байгуулагдсан. Одоо энэхүү нийгэмлэг 105 орны эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах нийгэмлэг, холбоод гишүүнээр элссэн байдаг бөгөөд ДЭМБ болон 4 тивийн эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах холбоод хамтран ажиллаж байна. Энэ нийгэмлэг нь ашгийн бус төрийн бус байгууллага юм. Нийт 6700 гаруй гишүүдтэй. Монгол улсын Эрхтэн Шилжүүлэн Суулгах Монголын холбоо хамтран ажилладаг. Манай улсаас 20 гаруй эмч нар энэ нийгэмлэгийн жинхэнэ гишүүн юм. Энэ нийгэмлэг нь Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах чиглэлээр байнгын үйл ажиллагаа явуулдаг. Эрхтэн хандивлах, авах, хадгалах, суулгах, эрдэм шинжилгээ, хуулийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, олон улсын онол практикийн хурал, семинар зохион байгуулах зэрэг 14 хороо ажилладаг байна. Нийгэмлэг өөрийн үйл ажиллагаа болон олон улсын конгресс хурал зохион байгуулахдаа доорх чиглэлүүдээр хамтарсан хурал зохион байгуулдаг.[3]

CELL TRANSPLANT AND REGENERATIVE MEDICINE SOCIETY	CTRMS	Cell Transplant and Regenerative Medicine Society
INTERNATIONAL PANCREAS AND ISLET TRANSPLANT ASSOCIATION	IPITA	ipita international pancreas & islet transplant association
INTERNATIONAL PEDIATRIC TRANSPLANT ASSOCIATION	IPTA	
INTESTINAL REHABILITATION AND TRANSPLANT ASSOCIATION	IRTA	Intestinal Rehabilitation & Transplant ASSOCIATION
INTERNATIONAL SOCIETY OF VASCULARIZED COMPOSITE ALLOTRANSPLANTATION	ISVCA	INTERNATIONAL SOCIETY OF VASCULARIZED COMPOSITE ALLOTRANSPLANTATION
INTERNATIONAL SOCIETY FOR ORGAN DONATION AND PROCUREMENT	ISODP	

[2] https://apps.who.int/iris/handle/10665/341814

[3] https://tts.org/

INTERNATIONAL XENOTRANSPLANTATION ASSOCIATION	IXA	International Xenotransplantation Association
SOCIETY OF PEDIATRIC LIVER TRANSPLANTATION	SPLIT	Society of Pediatric Liver Transplantation
TRANSPLANT INFECTIOUS DISEASE	TID	Transplant Infectious Disease

2.3. Global Observation on Donation and Transplantation (GODT)

Тус байгууллагыг ДЭМБ, TTS болон Испани улсын Трансплантацийн төв байгууллага (The Organozacion Nacional de Transplants) нар хамтран 2007 ондбайгуулсан. Эдгээр байгууллагууд 2008 онд ДЭМБ–тай нягт хамтран ажиллагч байгууллага болж гэрээ байгуулжээ. GODT байгууллагын гол зорилго нь дэлхийн улс орнуудад хийгдэж буй эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны үнэн бодит тоо баримтыг цуглуулан нэгтгэн дата бааз үүсгэн энэ төрлийн эмчилгээ үйлчилгээний үр дүнг тооцох, хяналт тавихаас гадна гарч болох алдаа эндэгдлээс тухайн орны эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамгаалах, эмчлүүлэгч нарын эрх ашиг, хүн болон хүний эс, эд, эрхтний наймаанаас сэргийлэх зэрэгт хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх юм. Манай улсын зохих байгууллага энэхүү байгууллагатай байнгын мэдээлэл солилцдог бөгөөд ингэснээр Монгол улсад хийж гүйцэтгэгдэж байгаа эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тоо баримт ДЭМБ болон TTS-д жил бүр бүртгэгдэж тооцогдож байдаг.[4]

Зураг 4



[4] http://www.transplant-observatory.org/

Зураг 5

Зураг 6



Зураг 7



2.4. Испани улс

Испани улсын Эрүүл мэндийн яамны харьяа Үндэсний шилжүүлэн суулгах байгууллага (The organizacion Nacional de Trasplantacion-ONT) нь тус улсын хэмжээнд Эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг зохицуулах төв байгууллага юм.Испани улс нь нийт 46.7 сая хүн амтай бөгөөд 1 сая хүн амд амьгүй донор нь 2019 оны байдлаар 49 хүн байсан бөгөөд 2022 онд энэ үзүүлэлтийг 50болгохоор ажиллаж байгаа юм. Энэ нь Испани улс амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийж байгаа амжилт, үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлж байгааг илтгэж байгаа юм. Энэ амжилтын үндэс нь энэхүү байгууллага нь орон даяараа Испани загвар гэдгийг төрийн дэмжлэгтэйгээр нэвтрүүлсэн явдал юм.

Зураг 8

Испани загвар

1. **Үндэсний шилжүүлэн суулгах байгууллага(ONT)**
   - Чанарын баталгааны хөтөлбөр
   - Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хялбар, байнга нэвтрэх боломжтой (нийгмийн эерэг уур амьсгал)
   - Сургалт
2. **Бүс нутгийн (17 автономит бүс)**
   - Бүс нутгийн зохицуулагч хариуцна
3. **Эмнэлгүүд (1989-20 эмнэлэг – 2009-170 эмнэлэг)**
   - Эмнэлгийн (ТС) нь боломжит хандивлагчдыг эрт илрүүлж, шилжүүлэхэд тус дөхөм болно
   - Эмнэлэг нь донор, шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд нь
   - Өргөтгөсөн шалгуур үзүүлэлтийг хандивлагчид ашиглах

Энэхүү байгууллага нь 1989 онд байгуулагдсан бөгөөд ДЭМБ болон TTS, GODT байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ байгууллагын үйл ажиллагааны гол чиглэл нь Амьгүй донорын үйл хэргийг олон түмэн, ард иргэдэд таниулан ухамсарлуулан ойлгуулах, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах, эрүүл мэндийн байгууллагуудад зохицуулагч ажиллуулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн донорын менежмент болон эд, эрхтэн шилжүүлэн суулгах чиглэлээр тасралтгүй сургалт, дадлагажилт зохион байгуулах; эмчилгээ үйлчилгээний талаарх мэдээлэл үр дүнг нэгтгэн дата үүсгэх, эмчилгээ үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг тооцох зэрэг үйл ажиллагааг хийдэг. Энэ үйл ажиллагааг улс орон даяар тархан байрласанDTI (Donation and Transplantation Institut) болон TPM (Transplantation Procurment Managment) гэдэг ашгийн бус төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гүйцэтгэдэг. Энэхүү үйл ажиллагааг нийт 120 гаруй хүний хүчээр хийж гүйцэтгэж байна.[5]

[5] http://www.ont.es/

2.5. Бүгд Найрамдах Солонгос улс

БНСУ 2020 оны байдлаар 51.7 сая хүн амтай. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийг анх 1999 онд баталж байсан ба энэ хуульдаа эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах байгууллага байгуулахыг зааж өгсөн бөгөөд тухайн ондоо Center for Korean Network for Organ Sharing (KONOS) гэдэг төрийн байгууллагыг байгуулсан байна. Энэхүү байгууллага нь Амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд орох хэрэгцээ шаардлагатай иргэдийг бүртгэн хүлээх жагсаалт (Waiting List) үүсгэж амьгүй донорын эрхтэнг шударга хуваарилах үйл ажиллагааг зохицуулдаг байна.Одоогоор нийт 76 эмнэлэгт ямар нэгэн байдлаар эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна. Эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг зохион байгуулах нарийн зохион байгуулалттай орнуудын нэг юм. Мөн 2010 онд хуулийн шинэчлэл хийх үедKorea Organ Donation Agency (KODA)байгуулахыг хуульчилсан байна.[6]

Зураг 9



Korea Organ Donation Agency (KODA) нь Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эмч, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалт, боломжит донорыг илрүүлэх үйл ажиллагаа, тархины үхлийг тодорхойлох, боломжит донорын гэр бүлээс зөвшөөрөл авах, донороос эрхтэн авах болон шилжүүлэн суулгах мэс заслыг зохион байгуулах, гэр бүлд дэмжлэг үзүүлэх, олон түмэнд эрхтний донорын үйл хэргийг таниулан ухамсарлуулан ойлгуулах зэрэг олон талт үйл ажиллагааг хийдэг байна.

[6] https://www.koda1458.kr/home.do

Солонгос улсад эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ улам өргөжин тэлж, эмчилгээ үйлчилгээний чанар сайжирч, тоо улам олон болсон тул эдгээрийг бүртгэлжүүлэх, тоо баримтыг үнэн бодиттойгоор цуглуулах, үр дүнг тооцох, хяналт хийх зэрэг асуудлууд урган гарсан тул 2014 онд KOTRY (Korean Transplantation Registry) гэдэг төрийн бус байгууллага байгуулагдан ажиллаж байгаа болно.

Мөн KODA байгууллагын мэдэлд KODA Lab буюу Солонгос улсын эд нийцлийн гол лаборатор болон Эдийн банк нь ажиллаж байна. Энэ байгууллагуудад нийтдээ 150 гаруй хүн ажиллаж байна.

2.6. Хорват улс

Хорват улс нь Европын шинэ тутам байгуулагдсан орон боловч Эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг сүүлийн жилүүдэд маш эрчимтэй хөгжүүлж байгаа орнуудын нэг юм. Хорват улсын хүн ам 4.5 сая орчим бөгөөд 4 эмнэлэгт эс, эд , эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг хийдэг ба 20 донор эмнэлэгтэй. Үйл ажиллагааны загвар нь Испани загвартай төстэй. Хорватын парламент 1999 онд Эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хууль баталсан.Тэр жилдээ Eurotransplant (ET)-ийн гишүүн болсон бөгөөд өөрийн улсдаа Regional Health Development Center on Donation and Transplant Medicine гэдгийг төрийн мэдэлд байгуулсан Эд, эрхтэн шилжүүлэн суулгах бүхий л үйл ажиллагааг зохицуулдаг байна. Одоо энэхүү байгууллагыг улам өргөтгөж South Eastern Europe Health Network болгон бүс нутгийн сүлжээ үүсгэн ажиллаж байна. Үүнд: Болгар, Молдав, Израиль, Хорват, Серби, Босни-Герцеговин, Албани,Македони, Румын зэрэг 9 улс орон нэгдсэн.Нийт энэ бүс нутагт 151.7 сая хүн ам амьдарч байна. Хорват улс нь 2000 онд 1 сая хүнд 2.7 амьгүй донорыг эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд донор болгож байсан бол 2011 гэхэд 1 сая хүн ам 33.6 донортой болсон байна.[7]

2.7. Словак улс

Мөн Европын холбооны гишүүн орон, хүн 5.8 сая Тус улсын Эрүүл мэндийн яамнаас 2013 онд Narodna Transplantacna Organizacia(NTO) гэдэг төрийн байгууллага байгуулсан байна. Энэ байгууллагын үйл ажиллагааны зорилго чиглэл нь дээрх орнуудын ижил төстэй байгууллагуудтай адил бөгөөд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг бүхэлд нь зохицуулдаг юм байна. Тус улсад 5 эмнэлэгт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ хийдэг бөгөөд 20 орчим донор эмнэлэг ажилладаг байна. Өнгөрсөн 2021 онд Амьгүй буюу Тархины үхэлд

[7] http://seehn.org/

хүрсэн нийт 60 донор гарсан бөгөөд 97 хүнд бөөр, 31 хүнд элэг, 21 хүнд зүрх, 2 хүнд уушги, 1 хүнд нойр булчирхай шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийсэн байна. 2022 оны хувьд одоогоор 10 тархины үхэлтэй донор гарсан бөгөөд 3 хүнд зүрх, 10 хүнд элэг, 1 хүнд уушги, 30 орчим хүнд шөрмөс, 10хүнд нүдний эвэрлэг шилжүүлсэн байна.[8]

2.8. Скандинавын орнууд

Энэ бүс нутагт Scandia Transplant гэдэг бүс нутгийн хамтын байгууллага байдаг. Энэ бүс нутгийн орнууд хамтарсан Waiting List буюу хүлээх жагсаалттай бөгөөд аль нэг оронд амьгүй донор гарсан үед Organ Sharing хийх бөгөөд энэхүү үйл ажиллагааг тухайн улс орнуудын эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах Координаторууд зохицуулдаг. Энэхүү үйл ажиллагааг тухайн орнуудын төрийн зүгээс дэмжиж, хянаж, үр дүнг тооцдог. Энд Швед, Финлянд, Норвеги, Дани, Исланд улс багтдаг. 2020 онд Эстони улс нэгдэн оржээ. Нийт энэ бүс нутагт 30 орчим сая хүн ам амьдардаг юм байна.[9]

2.9. АНУ -ын ЭМЯ-ныхаа харьяалал дор 50 мужид нийт 56 байгууллага Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулан ажиллаж байна.



[8] https://www.nto.sk/en/

[9] http://www.scandiatransplant.org/

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

1. Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томьёоны тодорхойлолтыг тусгана. Үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Насыг бууруулснаар донор болох боломжтой иргэдийн тоо нэмэгдэнэ. ➢ Залуу эцэг, эх хүүхдэдээ Донор болох боломж гарна.	➢ Хэт залуу байгаа нь шийдвэр гаргахад (бие дааж) өнгөц хийсвэр байж болох талтай. ➢ Гэр бүлийн бусад гишүүдээс санал авах, зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулах

2. Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоог тодорхойлж, Монгол Улсын засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрхийг тусгана. Мөн хүний эрхтэн эд, эс шилжүүлэн суулгахтай байгууллага, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүргийг тусгана.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Санхүүгийн дарамтгүй болсон тохиолдолд эцэг, эх болон гэр бүлийн гишүүд Донор болох боломжтой тохиолдол эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг нөхцөл илүү бүрдэнэ. ➢ Донор байгаа ч санхүүгийн боломжгүй байгаа тохиолдол шийдэгдэнэ	➢ Эрүүл мэндийн тухай хууль хүүхдэд үнэ төлбөргүй үйлчилнэ гэсэн заалт байдаг ➢ Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний зардлыг тухайн эмнэлгийн төсвийн төсөлд нэмж суулгах шаардлага гарна

3. Хуулийн гуравдугаар бүлэгт Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгах. Донор реципиент, эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлагыг тусгана.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Өнгөрсөн хугацаанд донорын гэр бүлтэй уулзах явцад 85-90% нь санхүүгийн дэмжлэг өгөх эсэхийг асууж байсан. Хэрвээ оршуулгын зардалд нэмэлт дэмжлэг үзүүлбэл донор болох магадлал, донорын тоо олширно. ➢ Мөнгийг Нийгмийн Даатгалаас шууд оршуулгын бүх үйл ажиллагааг зохион байгуулах компани руу шилжүүлэх ➢ Донорын эрхтнийг авч эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийсний	➢ Бэлэн мөнгөний харьцаа үүсгэхгүй байвал зохино.

дараа оршуулгын зардалд нэмэлт дэмжлэг үзүүлж байгаа учраас хүний эрхтний наймаа гэж үзэхгүй ➢ Донорын зөвшөөрлөө түрүүлж өгсөн байна.	

4. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт Эд шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгана.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Хуурамч гэрлэлтийг таслан зогсоох ➢ Хүний эрхтний наймаа, мөнгөний тохиролцоог зогсоох ➢ Донор болох хууль эрх зүйн орчин тодорхой болно	Байхгүй

5. Хуулийн тавдугаар бүлэгт Эс болон үр шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээтэй холбоотой эрх зүйн асуудлуудыг тусгана.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Гэр бүлийн тухай хуульд ураг төрөл заагдаагүй байдаг. Иймд уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ➢ Донорын олдцыг нэмэгдүүлнэ	➢ Иргэний бүртгэл мэдээллийн төвөөс эдгээр хүмүүс ураг төрөл гэсэн баталгаа албан бичиг авахад төвөгтэй байж болох талтай.

6. Хуулийн зургаадугаар бүлэгт Донороос эрхтэн, эд, эсийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх,боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах үйл ажиллагааны зохицуулалт

Эерэг тал	Сөрөг тал
➢ Нэгэнт амьд донор болсон иргэдийн эрхийг хамгаалах нь хууль ёсны хэрэг. Цаашид: ➢ Амьд донорын амьдралын чанарыг хамгаалах, тэднийг хүндлэх ➢ Амьд донорын ажил олгогч нарын зүгээс тухайн иргэнд ажлын байрны нөхцөл байдлыг өөрчлөх, байгууллагын дотоод журмын хүрээнд нэмэлт тусламж дэмжлэг үзүүлэх	➢ Амьд донор нэмэгдэх хандлага бий болж болзошгүй

7. Хуулийн долдугаар бүлэгт энэхүү үйл ажиллагаанд шаардагдах санхүү, хөрөнгө оруулалтын асуудлын зохицуулалтыг шинээр тусгана.

Эерэг тал	Сөрөг тал

➢ Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн эрх ашиг хамгаалагдана. ➢ Ёс зүйн хэм хэмжээнд үйл ажиллагаа явагдана. ➢ Гарч болзошгүй сөрөг үр дагавраас сэргийлнэ.	Байхгүй

8. Зорилго 12 дугаарт дурдсан санал буюу Нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулж ажиллуулах талаар журам боловсруулж батлах тухай заалтыг Донорын тухай хуульд байхгүй гэсэн шалтгаанаар журмын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас буцаагдсан.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Эрх зүйн баримт бичигтэй болно. ➢ Уг журам батлагдснаарНэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулагдаж олон улсын стандарт дагуу ажиллах боломж бүрдэнэ.	Байхгүй

9. Зорилго 13-14 дүгээрт дурдсан саналд одоогийн Донорын тухай хуульд эрхтэн шилжүүлэн суулгах, үр шилжүүлэн суулгах талаар голчлон заалт орсон байгаа болно. Эс, эд шилжүүлэн суулгах эмчилгээний талаар болон эс, эдийн банк байгуулах талаар заалт байхгүй байгаа бөгөөд Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тухай биеэ даасан хууль боловсруулан гаргах хэрэгцээ урган гарч байна.
10. Зорилго 15-19 дүгээрт эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах эмчилгээтэй холбоотой санхүүгийн асуудлуудыг тухайн хуульд нэмэлтээр оруулах саналууд байгаа болно.

Эерэг тал	Сөрөг тал
➢ Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ илүү үр дүнтэй, хүртээмжтэй болно. ➢ Донорын үйл хэрэгт оролцох эмнэлгийн байгууллага илүү идэвхтэй ажиллана. ➢ Дархлаа дарангуйлах эмийн хэрэглээ илүү хяналттай, хүртээмжтэй болно. ➢ Зохицуулах алба нь эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд гаргаж буй зардлыг тооцох боломжтой болно.	Байхгүй

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралтаас үзнэ үү.

4.1. Хүний эрхэнд үзүүлэх үр нөлөө

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсруулна. Ийнхүү боловсруулснаар талуудын эрх үүрэг, хариуцлага тодорхой болох бөгөөд хэн нэг нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэх хууль эрх зүйн орчин цогцоор бүрдэх юм. Хувь хүний эрхийг зөрчихгүй бөгөөд хэл, яс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл, эрэгтэй эмэгтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүйгээр хүн бүрт тэгш эрх, тэгш боломж олгох болно.

Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү үр нөлөөтэй байна.

4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг боловсруулах хувилбар нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага дэлхийн болон дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадвар, тогтвортой байдал, тэдний үйлдвэрлэлийн болон захиргааны зардал, макро эдийн засгийн хүрээнд, мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал, өрхийн орлого зарлага, олон улсын харилцаа зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт (хавсралт хүснэгт 2)-аас харагдаж байна. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар олон зуун иргэд маань эх орондоо дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн оношилгоо, эмчилгээ үйлчилгээг чанартай, хүртээмжтэйгээр хүртэх боломж бүрдэнэ. Ингэснээр гадаад улс руу энэ төрлийн эмчилгээ хийлгэхээр явахад зарцуулагддаг олон тэрбум төгрөг эх орондоо үлдэж гадагшаа чиглэсэн мөнгөний урсгал эрс багасна. Харин эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээг бүс нутгийн хэмжээнд чанартай, дэлхийн төвшинд хийж эхэлснээр гадаад улсаас манай улсад ирж энэхүү эмчилгээ, үйлчилгээ хийлгэх гадны иргэд олширч анагаах ухааны аялал, жуулчлал хөгжиж мөнгөний урсгал манай улс руу чиглэх болно. Энэ хэрээр эмчилгээний шинэ технологийг даган манай улсын анагаах ухааны салбар улам хөгжиж эмнэлгийн багаж хэрэгсэл, материал техник, аппарат хэрэгсэл илүү хангагдаж салбарын материаллаг байр суурь бэхжиж, хөгжлийн шинэ шатанд гарахад үнэтэй хувь нэмэр болно.

4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө

"Хуулийн төсөл боловсруулах" хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд нийгэмд үзүүлэх ямарваа сөрөг нөлөө байхгүй ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлнө. Эмчилгээний шинэ салбарын хөгжлийг дагаж хүний хөгжил улам дээшилж мэдлэг боловсрол сайтай, ажил мэргэжилдээ дур сонирхолтой олон хүн ажлын байртай болж цалин хөлс, урамшуулал илүү хангагдсанаар нийгэмд илүү эерэг үр нөлөө үзүүлнэ. Олон зуун иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн эмчилгээ үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүртэж амь явах, эрүүл байх эрх нь хангагдана. Гадаад улс

эмчилгээнд явдаг явдал чирэгдэл, сэтгэл санаа болон санхүүгийн дарамт үгүй болно.

4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. (Хавсралт хүснэгт 4)

4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийг боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хуультай уялдсан байна.

Энэхүү хуулийн төсөл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай үндсэн зарчмууд болон БНТУ-ын Истанбул хотод 2008 онд хуралдсан Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг (The Transplantation Society, TTS) болон олон улсын Бөөрний эмч нарын нийгэмлэгийн (International Society of Nephrology, ISN) хамтран зохион байгуулсан ээлжит хуралдааны үеэр Эрхтэн шилжүүлэн суулгах туризм болон эрхтний наймааны эсрэг Станбулын Тунхаглалын үндсэн үзэл баримтлалыг чандлан сахин, мөрдлөг болгоход чиглэн боловсруулагдсан байна. Мөн Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хорооноос 2019 онд батлагдсан Монгол улсын эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах ёс зүйн удирдамжтай уялдан гарч байгаа болно.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасны дагуу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Донорын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл тус тус боловсруулна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх ;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх; гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дүгнэлт гаргахаар

заасан болов Аргачлалын 5.4-т "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлалын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол" гэж

заасны дагуу "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн хувилбарыг сонгосон байна.

Иймд Аргачлалын 7.1-д заасны дагуу зохицуулалтын хувилбар тус бүрийн эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулж дүгнэх хэсгийг хийх шаардлагагүй байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хуулийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд Аргачлалын 8-д заасны дагуу олон улсын эрх зүйн зохицуулалт, бусад орны адил төстэй эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх зорилгоор дараах улсуудад Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн зохицуулалтын асуудлыг хэрхэн хуульчилсан байдлыг судаллаа.

6.1. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай үндсэн зарчмууд 2020

Швейцарь улсын Женев хотод 1987 оны 5 дугаар сард хуралдсан ДЭМБ-ын 40.13 ассамблейд анх удаа хүний эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар (WHA40.13) үндсэн зарчим, стандарт байх талаар шийдвэр гарч WHA 44.25 буюу 1991онд хуралд ДЭМБ-ын 44 дүгээр ассамблейн чуулганаар буюу WHO Guiding Principles on human cell, tissue and organ transplantation буюу ДЭМБ-ын Хүний эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай үндсэн зарчмуудыг баталсан. Энэ нь нийт 11 зарчимтай юм. Зарчмуудын гол үзэл санаа, утга агуулга нь хүнд эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах эмчилгээг амьд болон амьгүй донороос хийхдээ хууль журмын хүрээнд сайн дурын үндсэн дээр эрх тэгш, ялгаварлан гадуурхалгүй, ёс зүйн хэм хэмжээнд, хүн болон хүний эрхтний наймаа болон ашиг орлого олох сонирхлоос ангид байж аюулгүй, чанар, сайн үр дүнтэй хийгдэж байх ёстой гэж заасан байдаг. Мөн эмчилгээний үр дүн түүний талаарх мэдээлэл бүртгэгдэж, хянагдан ил тод байх ёстой гэсэн байдаг. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хийж байгаа Дэлхийн 93 улс орон энэхүү зарчмыг баримталж байгаа бөгөөд энэ зарчмуудад тулгуурлан өөрийн орны эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаа, харилцааг зохицуулах хууль, дүрэм журмыг гаргасан байдаг.

6.2. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Өнөөгийн байдлаар АНУ-д 1984 онд батлагдсан Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуульд донор 18 настай тус улсын иргэн өөрөө донор болох хүсэлтээ илэрхийлж болно гэсэн зохицуулалттай байдаг. Мөн АНУ-ын Эрхтэн болон эд шилжүүлэн суулгах талаар хамтад нь зохицуулдаг бөгөөд эсийг эмчилгээний зориулалтаар ашиглах тухай хууль нь тусдаа биеэ даасан хууль болон батлагдсан байдаг. АНУ-ын засгийн газраас 1987 онд Ясны чөмөгнөөс үүдэл эсийг ашиглах (Legislation/Blood Stem Cell) , 1990 онд Ур шилжүүлэн суулгах тухай хуулийг баталсан байна. (Human Fertilization and Embryology Act 1990)

6.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Тус улс нь 2000 онд батлагдсан Эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуульд амьд болон тархины үхэлтэй донорын насны талаар тусгасан. Уг хуулиар амьд Донорын насыг 18 гэдгээр тогтоосон байдаг. БНСУ-д Донор болсон иргэний гэр

бүлд оршуулгын зардлын дэмжлэгийг бэлэн мөнгөний харьцаанд орохгүйгээр үзүүлдэг.

6.4. ИСПАНИ УЛС

Эрхтэн шилжүүлэн суулгалт, ялангуяа тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэн суулгалтаар дэлхийд тэргүүлдэг. Испани улс нь одоогийн баримталж буй Эрхтэн шилжүүлэн суулгалтын тухай хуулиа 1979 онд баталсан. Донорын нас амьд донорын хувьд 18, тархины үхэлтэй донорт насны дээд доод хязгаарыг 2 сартайгаас 80 нас гэж мөрдөн ажилладаг байна.

6.5. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛС

Европын холбооны улсын зөвлөлөөс (Council of Europe) 2017 онд Safety, quality and ethical matters related to the use of ORGANS, TISSUES AND CELLS OF HUMAN ORIGIN гэдэг хууль журмыг EDQM буюу European Directorate for the Quality of Medicines and HealthCare байгууллагаас энэхүү журмыг батлан гаргасан бөгөөд дахин 2018 онд шинэчлэл хийсэн байна. Энэхүү заавар, журамд хүний эрхтэн, эд, эсийг эмчилгээний зориулалтаар хэрхэн ашиглах талаар цогцоор нь зааж өгсөн байна.

6.6. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Анх хүний эрхтэн ,эд шилжүүлэн суулгах тухай хуулийг 1992 онд баталсан бөгөөд нийт 4 удаа шинэчлэн найруулж байсанбайна. Сүүлд 2020 онд дахин нэмэлт өөрчлөлт хийжээ. Энэхүү хуулиар амьд болон амьгүй донороос эрхтэн, эд шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулахаар заасан байна. (ЗАКОНРОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ - О трансплантации органов и (или) тканей человека)

6.7. ИСТАНБУЛЫН ТУНХАГЛАЛ

БНТУ-ын Станбул хотод 2008 онд хуралдсан Дэлхийн эрхтэн шилжүүлэн суулгах нийгэмлэг (The Transplantation Society, TTS) болон олон улсын Бөөрний эмч нарын нийгэмлэгийн (International Society of Nephrology, ISN) хамтран зохион байгуулсан ээлжит хуралдааны үеэр Эрхтэн шилжүүлэн суулгах туризм болон эрхтний наймааны эсрэг Истанбулын Тунхаглалыг баталсан юм.(The Declaration of Istanbul on Organ Trafficking and Transplant Tourism). Энэхүү тунхаглалыг батлахад 78 орчим орны ЭМЯ-ны сайд болон удирдах ажилтан болон Олон улсын 80 гаруй нийгэмлэг, холбоодын төлөөлөл болсон нийт 150 гаруй хүн гарын үсэг зурж баталсан байдаг. Тухайн үед дэлхийн улс орнуудад хийгдэж байсан эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний 10 гаруй хувь нь эрхтний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмтэй холбоотой байна гэсэн статистик гарсан байна. Зөвхөн ганцхан жишээ дурдахад Пакистан улсад 2006 онд 2000 бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ хийсэн байсан бөгөөд үүний гуравны хоёрт нь гадаад улсаас ирсэн иргэнд энэ эмчилгээг хийсэн байжээ. Энэ НҮБ-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Хүн эрүүл, амьд байх эрхтэй гэдэг үзэл санааг ноцтой зөрчиж байна гэж уг тунхаглалд заажээ. Манай улс 2018 онд Испани улсын Мадрид хотод болсон TTS- ийн 27 их хурлын үеэр энэхүү тунхаглалд нэгдэн орсон болно.[10]

---

[10] https://www.declarationofistanbul.org/

6.8. ЭС, ЭД, ЭРХТНИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ АЛБА

Донорын тухай хууль анх 2000 онд батлагдсан. 2012 он болон 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан. Шинэчлэгдэн батлагдахдаа Донорын тухай хуулийн 7.1.4 дэх хэсэгт Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах албан байгуулах гэж тусгагдсан. Энэхүү заалтын дагуу тухайн хуулийн 9 дүгээр зүйлд Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны чиг үүргийг зааж өгсөн байдаг. Эрүүл мэндийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн "ЭМХТ-ийн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай" А/70 дугаар тушаал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн Б/40 дүгээр тушаалаар 6 орон тоотой алба байгуулагдан ажиллаж байна. Тус алба нь Донорын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн Зохицуулах албаны эрх үүргийн хүрээнд Монгол улсын хэмжээнд Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний хэрэгжилтийг хангах, донорын үндэсний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

1. Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж, эрүүл мэндийн байгууллагуудыг бодлого, арга зүйгээр хангах, хяналт тавих, үр дүнг тооцох;
2. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний заавар удирдамжийг багуудтай хамтран шинэчлэн боловсруулж, батлуулах;
3. Тархины үхэлтэй донор илрүүлэх, эрхтэн хамгаалах эмчилгээг эрчимт эмчилгээний тасагт хийх үйл ажиллагааг нэгдсэн чиг удирдлагаар хангах, ажлыг өргөжүүлэх;
4. Нэгдсэн бүртгэл мэдээний санг бүрдүүлэх, ажиллуулах, нэгтгэсэн мэдээг ЭМЯ болон холбогдох байгууллагад хүргүүлэх;
5. Эд, эрхтэн хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах;
6. Донорын зөвшөөрлийн хуудсыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
7. Гадаад улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчдийн дархлаа дарангуйлах эмийн зохицуулалтыг хийх ажлыг зохион байгуулах;
8. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгуулсан болон донорын амьдралын чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгаа хийх, тайлагнах;
9. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээнд ороцлож буй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, цалин хөлс нийгмийн баталгааг сайжруулах;
10. Донорын үйл ажиллагааг таниулах сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
11. Анагаах ухааны шинэ технологийг эмчилгээнд нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах / эс,эдийн болон хүйн цусны банк байгуулах, үйл ажиллагааг зохицуулах/;
12. Гадаадын ижил чиг үүрэгтэй байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх, өргөжүүлэх;

Энэ хугацаанд ЗА нь ЭМС –аар Донорын тухай хуулийг дагаж мөрдөх журмуудыг (2018 он.12 сард А/500,А/501,А/502,А/503, А/504, А/505 болон 2019 онд А/164) боловсруулан батлуулж үйл ажиллагааны мөрдлөг болгон ажиллаж байгаа болно. ЭМС-ын 2019 онд баталсан А/164 дүгээр тушаал нь 2022 онд дахин шинэчлэгдэн батлагдаж А/198 дугаар тушаал болсон. Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах Хамтран ажиллах гэрээг УНТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, ЭМХТ-ийн ЗА хамтран байгуулан ажиллаж 2022 оны 3 дугаар сард үйл ажиллагаагаа дүгнэсэн. Мөн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах Ёс зүйн удирдамжийг боловсруулан ЭМЯ-ны Ёс зүйн хороогоор батлуулсан. Зорицуулах албаны үндсэн чиг үүргийн хүрээнд 2018 оноос 2023 оны 12 дугаар улирлын байдлаар нийт 7000 орчим удаа донор эмнэлгүүдээс мэдээлэл авч 435 удаа донор эмнэлэгт очиж ажиллаж 259 тархины үхэлтэй боломжит донор илрүүлсэн. Илрүүлсэн 256 тархины үхэлтэй боломжит донорын 64 нь шалгуурт тэнцэж гэр бүлтэй уулзан донор болгох хүсэлт тавих уулзалт зохион байгуулан 26 гэр бүлээс зөвшөөрөл авсан. Зөвшөөрөл авсан 3 донорын амин үзүүлэлт унаж зүрх зогссон тул үйл ажиллагааг бүрэн зогсоосон. Үлдсэн 23 бодит донороос 35 хүнд бөөр, 23 хүнд элэг, давхардсан тоогоор 150 удаа шөрмөс авах, шилжүүлэн суулгах мэс заслыг донор эмнэлэг болон эрхтэн шилжүүлэн суулгах багуудтай хамтран хийх үйл ажиллагааг шилжүүлэн амжилттай зохион байгуулан 58 хүний амь насыг аварч амьдрал бэлэглэж 160 гаруй хүний амьдралын чанарыг дээшлүүлээд байна.

Зураг 10. Зохицуулах албаны Амьгүй донор илрүүлэх үйл ажиллагааны инфограмм



Эдгээр эмчилгээний тусламж үйлчилгээг гадаад улсад эмчлүүлэх хамгийн бага тооцоогоор бодож үзэхэд 30орчим тэрбум төгрөгийг хувь хүний халаас болон төсвөөс хэмнэсэн гэсэн тооцоо гарсан.

Түүнчлэн ДТХ-ийн нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт тус албаны мэргэжилтнүүд орж ажиллаж 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдөр уг нэмэлт өөрчлөлт батлагдаж амьд донор болох хүний насыг 21 нас болгон өөрчилснөөр ойролцоогоор 300 гаруй мянган иргэний донор болох эрх нээгдсэн.

ЗА-наас анх санаачилж дэвшүүлсэн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв байгуулах төсөл МУЗГ-ын мөрийн хөтөлбөрт орсон бөгөөд 2024-2026 онд барьж байгуулагдахаар улсын төсөвт нийт 140 тэрбум ₮ тусгагдснаас ирэх 2024 онд 40 тэрбум₮-өөр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хуультай уялдсан байна.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасны дагуу Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Донорын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл тус тус боловсруулна.

Хавсралт 1: Хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчиндүзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. **Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх**	**1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	**Тийм**		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх			
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	**Тийм**		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	**Тийм**		Шударга ёсны зарчимд нийцнэ
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		**Үгүй**	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		**Үгүй**	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		**Үгүй**	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	байршил өөрчлөгдөхийг оролцуулан)			
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бус нутаг, салбарууд	8.1.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарахгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		**Үгүй**	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		**Үгүй**	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

Эрүүл мэндийн хөгжлийн төв

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл/

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн ерөнхий мэдээлэл/

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн[1] 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг батлагдснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасны дагуу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл[2] /цаашид "хуулийн төсөл" гэх/ батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ыг баримтлан зардлыг тооцоог хийнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаар санал боловсруулах, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа эрхтэн, эд, эсээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох үндсэн зорилготой юм.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төслөөр Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээд болон төрд үүсэх зардлыг тооцохоор боллоо.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нийлээд байсан тул аргачлалыг үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Манай улсын хэмжээнд 2004 оноос өнөөг хүртэл ойролцоогоор 600 орчим хүн элэг болон бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг гадаад улс орнуудад

---

[1] Хууль тогтоомжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

[2] Түс зарлын тооцооны тайланг гүйцэтгэхдээ Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийн эхний хувилбарт үндэслэсэн болно.

хийлгэсэн байна. Эдгээрийн 65% нь БНЭУ-д, 23 % нь БНСУ-д үлдсэн 12% нь бусад улс оронд (БНХАУ, Сингапур, БНТУ, АНУ гм) энэхүү эмчилгээг хийлгэсэн байна. Судлаачдын тооцоогоор Энэтхэг улсад Элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээний зардал ойролцоогоор 35-50 мянган USD буюу 200 сая ₮, Солонгос улсад 120-200 мянган USD буюу 500 гаруй сая ₮ , бусад улсад 200-350 мянган USD буюу ойролцоогоор 800 гаруй сая ₮ болж байна. Энэ тооцоог хамгийн бага зардлаар эмчлүүлэгч , донор, сахиурын хамт байхаар тооцсон байна. Өнөөгийн байдлаар (2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр) УНТЭ-т бөөр шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг 331 хүнд, элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг 239 хүнд , ясны чөмөг үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг 32 хүнд, Хавдар судлалын үндэсний төвд 123 хүнд элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг тус тус амжилттай хийж олон зуун иргэдийг гадаад улсад өндөр үнэ өртөгөөр эмчилгээ хийлгэх эдийн засгийн болон сэтгэл санааны дарамт, явдал чирэгдлээс хамгаалсан байна. Эдгээрээс 58 хүнд буюу 35 хүнд бөөр, 23 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амьгүй донороос энэхүү эмчилгээг хийлгэсэн байна.Зөвхөн УНТЭ болон ХСҮТ эмнэлгүүдэд хийгдсэн элэг шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн 357 тохиолдолд 200 сая₮ -ний зардал гаргасан байна. Үүнийг хамгийн багаар тооцож үзэхэд 70 гаруй тэрбум₮ дотооддоо авч үлдсэн гэх тооцоо гарч байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллагад гүйцэтгэлээр нь тооцож олгодог болсонтой холбоотойгоор бөөр болон элэг, ясны чөмөг үүдэл эс , шөрмөс шилжүүлэн суулгах зэрэг эмчилгээний тоо эрс өссөн нь илүү олон хүний амь насыг аврах, эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэх боломж нээгдсэн. Зөвхөн 2023 онд УНТЭ-т 39 хүнд бөөр, 50 хүнд элэг, ХСҮТ-д 50 хүнд , ЭХЭМҮТ-д 1 хүүхдэд тус тус элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийсэн бөгөөд 1 жил амьдрах үр дүн нь 100%, 98%, 98%, 100% тус тус байна.



Хүснэгт 1. Сүүлийн 2 жилд бөөр, элэг шилжүүлэн суулгах эмчилгээ 2 дахин өссөн нь харагдаж байна.

Цаашдаа энэ үзүүлэлт 10-15% өсөх тооцоог гаргасан байна. (Ц.Амаржаргал нар УНТЭ.)

Донорын тухай хууль 2018 оны 1 дүгээр сард шинэчлэгдэн батлагдахад Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба байна гэж заасан бөгөөд тухайн оны 03 сарын 1 өдрийн ЭМСайдын А/70 дугаар тушаалаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулж энэхүү албыг тус төвийн харьяанд 6 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байна. Энэ хугацаанд жил бүр 160 гаруй сая төгрөгний цалин, 20 орчим сая төгрөгний урамшуулал авч ирсэн бөгөөд 175 сая төгрөгний үнэ бүхий эд хөрөнгө ашиглаж, 10-15 сая төгрөгний томилолт, сургалтыг зохион байгуулж иржээ. Мөн 7000 гаруй удаа Амьгүй донор буюу Тархины үхэлтэй донор илрүүлэх тандан судалгаа хийж 28 бодит донороос 35 хүнд бөөр, 23 хүнд элэг шилжүүлэн суулгах эмчилгээг хийлгэж 58 хүний амь нас эрүүл мэндийг сахин хамгаалах боломжийг бүрдүүлсэн байна.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдснаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шатаар тооцоолно. Үүнд:

- Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох,
- Нэг бүрийн зардлыг тооцох,
- Тоон үзүүлэлтийг тооцох,
- Нийт зардлын дүнг тооцох,
- Хялбарчлах боломжийг шалгах,
- Нэмэлт зардлыг тооцох,

2.1 Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрийг тогтоох:

Хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүсч байгаа үүргийн хүрээнд зардлын тооцоог хийх болно. Хуулийн этгээдэд зардал үүсгэх дараах үүргүүд байна.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаар Засгийн газар:

- Эрүүл мэндийн талаарх баримтлах бодлогын хүрээнд эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж үйчлилгээний талаар баримтлах бодлогыг батлах, биелэлтийг хангах;
- Засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн асуудал эрхтэн төрийн захиргааны төв байгууллагыг үндэслэн Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагыг байгуулах;
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх үүрэг

- Эрхтэн, эд эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйл ажиллагааны талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх үүрэгтэй:
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд хяналт тавих;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллагын дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тогтолцоог бүрдүүлэх, түүнтэй холбогдон гарах зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах цогц үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох журам, заавар, стандартыг батлах;
- эрхтэн, эд, эсийн донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулах, сангийн ажиллах журмыг батлах;

- Эрүүл мэндийн тухай хуулийн 26.5-д заасан мэргэжил, ёс зүйн хороог ажиллуулах, тус хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээтэй холбоотой эмнэлгийн мэргэжилтэнг сургалт, хүний нөөц бэлтгэх, нэгдсэн бодлогыг баримтлах;
- амьд донор болон реципиентийн урт хугацаан дах хяналтыг хөгжүүлэх, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн зохих эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх;
- дархлаа дарангуйлах эмийн эмчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс хариуцах;
- амьгүй донорыг илрүүлэх үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгаж шийдвэрлэх;
- энэ хуульд заасан эрхтэн, эд, эс авах мэс заслыг донор эмнэлэгт хийх нөхцөл бололцоог хангах, донор эмнэлэг, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, төв хамтран ажиллах гэрээг батлах
- Донор эмнэлэг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтний мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тухайн эмнэлгийн боломж чадавхийг сайжруулахад бодлогоор дэмжиж ажиллах; инноваци
- Эд, эсийн сан байгуулах нөхцлийг бүрдүүлэх, нөөцийг бүрдүүлж нөхөн хангалт хийх
- Эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд хэрэглэх эд, эсийн сантай байна.
- хуульд заасан бусад эрх, үүрэг.

<u>Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн байгууллагын эрх үүрэг</u>

<u>Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах чиглэлээр</u>:

- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- донор эмнэлэг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл, журмыг боловсруулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээтэй холбоотойгоор иргэн, эмчлүүлэгч нарт эрсдэл үүсэх, хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний явцад донор эмнэлэг болон эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагаас гарч буй зардал, цалин, урамшуулал, илүү цагийн хөлс зэргийг тооцож төсөв болон гүйцэтгэлийн санхүүжилтэд санал тусгаж холбогдох байгууллагад хүргүүлэх.

<u>Сургалт, судалгаа, хамтын ажиллагааны чиглэлээр:</u>

- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтран эмнэлзүйн судалгаа

хийх, тайлагнах, үр дүнг тооцох, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;

- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллага болон төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, ухуулан таниулах, ойлгуулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах.
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллаганы нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ажиллуулах бөгөөд ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны үндэсний хүлээх жагсаалтад бүртгэх, хуваарилах, хяналт тавих;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний талаарх мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, дүн шинжилгээ судалгаа хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах.

Амьгүй донорыг илрүүлэх, хуваарилах чиглэлээр:

- Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан байгууллага амьгүй донорыг илрүүлэх, тархины үхэл тодорхойлох баг байгуулах;
- улсын хэмжээнд амьгүй донорын тандалт хийх, илрүүлэх тогтолцоог бий болгох, уялдуулан зохион байгуулах, багуудын чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, хяналт тавьж хамтран ажиллах;
- амьгүй донор илрүүлэх болон тандалт хийх үйл ажиллагааг зохион байгуулах;
- амьгүй донорын гэр бүлтэй уулзах, эрхтэн, эд, эсийн донор болгох хүсэлт тавих;
- амьгүй донорыг бүртгэх, сонгох, эрхтэн, эд, эс авах, шинжлэх, нийлүүлэх, хуваарилах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, хянах үйл ажиллагааг энэ хуулийн 13.2-д заасан журмын дагуу гүйцэтгэх;

Ёс зүй, олон нийттэй харилцах чиглэлээр:

- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, донор эмнэлгийн, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьж эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ёс зүйн хороотой хамтран ажиллах;
- эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг энэ хуулийн 21.5.1-д заасан ёс зүйн хороонд хүргүүлэх;
- хүний наймаа болон хүний эрхтэн, эд, эсийн наймаатай холбоотой ямар нэгэн хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллагад мэдэгдэх;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, ухуулан таниулах, ойлгуулах үйл

ажиллагааг боловсролын болон хэвлэл мэдээллийн байгууллагатай зохион байгуулах;
- Хууль тогтоомжид заасад бусад чиг үүрэг хэрэгжүүлэх.

<u>Эрүүл мэндийн байгууллагын эрх үүрэг</u>

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага байх ба тус байгууллагын бүтцэд төрөлжсөн тасаг эсхүл мэргэжлийн баг ажиллана.
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- Амьд донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх, хяналт тавих;
- Энэ хуулийн 21.4.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;/**амьгүй донорыг илрүүлэх, тархины үхэл тодорхойлох баг байгуулах/**
- реципиентэд тавих нөхцөл, шаардлага, үзүүлэлт хангасан хүнийг хүлээх жагсаалтад бүртгүүлэхээр энэ хуулийн 21-д заасан байгууллагад мэдээллэх; **/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн байгууллага/**
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг энэ хуулийн 21.3-д заасан санд тухай бүр оруулна; **/Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллаганы нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ажиллуулах бөгөөд ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална/**
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг эрх бүхий байгууллагаас батлагдсан журам, заавар, стандарт, технологийн дагуу гүйцэтгэх;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах;
- эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэн бэлтгэх, сургах, хүний нөөцийг чадавхжуулах;
- эрхтэн, эд, эсийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний явцад тохиолдож болох хүндрэл, эрсдэлээс сэргийлэх;
- донорын эрхтэн, эд, эсийг авах шинжлэх, боловсруулах, хадгалах, шилжүүлэн суулгах ажилбар болон эмчилгээний шинэ технологи, арга аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- амьд донор болон реципиентэд урт хугацаанд хяналт тавих;
- аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн зохих эмч, мэргэжилтэнд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах талаар сургалт зохион байгуулах;
- Реципиент эмнэлгийн мэргэжлийн баг нь эрхтэн, эд, эс авах мэс заслыг гүйцэтгэнэ.
- .Амьгүй донорыг зөөвөрлөх боломжгүй тохиолдолд тухайн донор байрлаж буй эрүүл эмнэлгийн байгууллагад эрхтэн, эд, эс авах мэс заслыг гүйцэтгэнэ.

- Эрхтэн, эд, эс шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах чиглэлээр / Донор, реципиентийн эрхтэн, эд, эсийг авах, эд, эсийн тохироо үзэх, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, устгах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэнэ/

Донор эмнэлэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- эмнэлгийн бүтцэд тархины үхэл тодорхойлох мэргэшсэн баг ажиллуулах;
- амьгүй донорыг илрүүлэх, оношлох, эмчлэх, эрхтэн хамгаалах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах;
- амьгүй донор эмчлүүлж буй төв, тасаг, хэсгийн эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцийг чадавхижуулах, бэлэн байдлыг хангуулах;
- амьгүй донорын талаарх мэдээллийг энэ хуулийн 21-д заасан байгууллагад тухай бүр мэдээлэх;
- эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагаас ажиллах багийн үйл ажиллагааг дэмжин ажиллах, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх;
- тухайн эрүүл мэндийн байгууллагад донорын эрхтэн, эд, эсийг авах мэс заслыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд амьгүй донорын эрчимт эмчилгээг үргэлжлүүлэх, зөөвөрлөх бэлэн байдлыг хангуулах талаар зохицуулах албатай хамтран ажиллах;
- энэ хуулийн 12.5-д заасны дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Санхүүжилтийн тогтолцоо

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг олон нийтэд таниулан ойлгуулах, ухамсарлуулах нөлөөллийн үйл ажиллагаа, донорын үйл хэрэг, шилжүүлэн суулгах, эрчимт эмчилгээ, хяналт, судалгаа шинжилгээ, сургалт, эс, эдийн банк байгуулах, хадгалах, тээвэрлэх, мэдээллийн сан үүсгэх, үр дүнг тооцохтой холбоотой санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ
- Донорын эрхтэн, эд, эсийг эмчилгээний зориулалтаар авах, шилжүүлэн суулгах үйл ажиллагааны санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, реципиентийн төлөх төлбөр, Засгийн газрын тусгай сан, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- Донорын эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
